



МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙН ЗАСАГЛАЛ ДАХЬ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООНЫ ОРОН ЗАЙН ҮНЭЛГЭЭ

Эцсийн тайлан

2/1/2024



Тайлангийн эхний хувилбар хүлээлцэх хүснэгт:

Тайлан илгээсэн огноо	2024 оны Нэгдүгээр сарын 2
АМЕП 2-т хүлээн авсан хүний овог, нэр	С.Солонго
Гарын үсэг	
Илгээсэн зохиогчийн нэр	Н.Дорждарь

Эцсийн тайлан хүлээлцэх:

Эцсийн тайлан хүлээлцэх	
Эцсийн тайлан илгээсэн огноо	
Хүлээлгэн өгсөн зохиогчийн овог, нэр	
Хүлээн авсан хүний овог, нэр	
Гарын үсэг	
Батлав. Овог, нэр	
Гарын үсэг	
Баталсан огноо	

Мэдэгдэл

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Түүнчлэн энэхүү тайлангийн агуулгыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа хэрэг биш бөгөөд мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг ч батлахгүй. Тайланд багтсан тоо баримт, мэдээ материал алдаа дутагдалтай байхыг үгүйсгэхгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно

Энэ тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй.

Хөтөлбөр хэрэгжүүлэгч

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр (АМЕП 2)-ийг Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам (Австралийн тусламжийн хөтөлбөр) санхүүжүүлж, Адам Смит Интернэйшнл зөвлөх компани хэрэгжүүллээ.

Зохиогчид

Намхайжанцангийн Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн менежер

Наранбаатарын Золжаргал, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн мэргэжилтэн



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Гарчиг

Зохиогчид.....	4
Зураг	6
Хүснэгт	8
Хураангуй	9
1. Монгол Улс дах иргэний нийгмийн орон зай ба уул уурхайн танилцуулга	16
1.1. Оршил	16
1.1.1. Олон сорилттой тулсан, эдийн засгийн гол салбар	16
1.1.2. Эрч хүчтэй ч, хязгаарлагдмал иргэний нийгмийн орчин	19
1.1.3. Уул уурхай дах иргэний нийгмийн орон зайн талаарх буруу ойлголт	26
1.2. Судалгааны зорилго, зорилт, аргачлал	27
2. Судалгааны гол үр дүнгүүд	32
2.1. Хувьсан өөрчлөгдөж буй олон хэв шинжит иргэний нийгэм.....	32
2.2. Ил тод байдал, нутгийн иргэдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд	45
2.3. Чадавхаа хөгжүүлэх, нарийн мэргэших нь иргэний нийгмийн нэн тэргүүний зорилт	50
2.4. Иргэний нийгмийн ачаар олон асуудлыг өөрчилж чадсан	53
2.5. ИНБ-уудын үйл ажиллагааны үндэс нь үр дүнтэй оролцоо, түншлэл	56
2.6. Шинэ, хуучин сорилтуудыг шийдвэрлэхэд илүү сайн уялдаа холбоо, хамтын ажиллагаа чухал 61	
2.7. Төр засаг, бусад оролцогч талуудын дэмжлэг амин чухал хэвээр байна	73
3. Дүгнэлт, зөвлөмжүүд.....	77
3.1. Онцлох үр дүнгийн товчоон, дүгнэлтүүд.....	77
3.2. Зөвлөмж.....	78
4. Хавсралт	80
5. Ишлэл	98

Зураг

Зураг 1. Байгалийн баялгийн тунхаг дах шийдвэрийн хэлхээ.....	17
Зураг 2. Бүртгэлтэй ТББ болон бусад хуулийн этгээдийн хувьсал	20
Зураг 3. Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын бүртгэлийн байдал.....	32
Зураг 4. Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын үйл ажиллагааны чиглэл.....	33
Зураг 5. ИНБ-уудын байгуулагдсан огноо, таван жилээр	34
Зураг 6. ИНБ-уудын орон тооны ажилтны тоо	35
Зураг 7. ИНБ-ын ажиллагсдын хүйсийн харьцаа	35
Зураг 8. ИНБ-уудын удирдлагын хамрах насны бүлэг	36
Зураг 9. ИНБ-уудын удирдлагын хүйсийн харьцаа	36
Зураг 10. ИНБ-уудын жилийн төсөв	37
Зураг 11. ИНБ-уудын санхүүжүүлэгчид	38
Зураг 12. ИНБ-уудын үзүүлдэг зөвлөх үйлчилгээ, үндсэн үйл ажиллагаанд эзлэх хувиар	39
Зураг 13. ИНБ-аас зөвлөх үйлчилгээ авдаг харилцагчид.....	39
Зураг 14. ИНБ-уудын эвсэл, холбоо.....	40
Зураг 15. ИНБ-уудын уул уурхайн засаглалтай холбоотой үйл ажиллагааны гол чиглэлүүд.....	41
Зураг 16. Уул уурхайн засаглал дах ИНБ-уудын оролцооны хэлбэрүүд	43
Зураг 17. Амжилттай хэрэгжсэн төслүүдийн үйл ажиллагааны чиглэл.....	55
Зураг 18. ИНБ-уудын хамтрагч талууд, сүүлийн гурван жилийн байдлаар	56
Зураг 19. ИНБ-уудтай сул хамтын ажиллагаатай оролцогч талууд, сүүлийн гурван жилийн байдлаар	57
Зураг 20. ИНБ, төр засгийн харилцааны сувгууд.....	57
Зураг 21. ИНБ, уул уурхайн компанийн албан тушаалтнуудын харилцааны сувгууд	58
Зураг 22. ИНБ хоорондын харилцааны сувгууд	59
Зураг 23. ИНБ-уудын зүгээс хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх хүсэлтэй оролцогч талууд.....	60
Зураг 24. ИНБ-уудын зүгээс хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй бодлогын чиглэлүүд.....	60
Зураг 25. ИНБ-уудад тулгардаг хамгийн том сорилтууд, сүүлийн таван жилийн байдлаар	61
Зураг 26. ИНБ-уудад тулгардаг эрх орчинтой холбоотой бэрхшээлүүд.....	62
Зураг 27. ИНБ-уудад нийтлэг тулгардаг эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлүүд, сүүлийн таван жилийн байдлаар.....	62
Зураг 28. ИНБ-уудад тулгардаг эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлүүд, эх үүсвэрээр.....	63
Зураг 29. ИНБ-уудад тулгардаг практик бэрхшээлүүд.....	64
Зураг 30. ИНБ-уудад түгээмэл тулгардаг практик бэрхшээлүүд	64
Зураг 31. ИНБ-ууд үйл ажиллагаа явуулдаг орчноо дүгнэсэн байдал.....	65
Зураг 32. ИНБ-ын үйл ажиллагааны орчинд гарсан өөрчлөлт, сүүлийн таван жилийн байдлаар	65
Зураг 33. ИНБ-ын үйл ажиллагааны орчинд гарсан өөрчлөлт, сүүлийн хоёр жилийн байдлаар.....	66
Зураг 34. Төр засагтай ИНБ-уудын харилцдаг хамгийн үр дүнтэй сувгууд, сүүлийн таван жилийн байдлаар	66
Зураг 35. Уул уурхайн компаниудтай ИНБ-уудын харилцдаг үр дүнтэй сувгууд, сүүлийн таван жилийн байдлаар.....	67
Зураг 36. ИНБ-уудыг дарамталдаг, айлган сүрдүүлдэг эсэх	68

Зураг 37. ИНБ-уудад тулгардаг дарамт шахалт, айлган сүрдүүлэлтийн хэлбэрүүд	68
Зураг 38. ИНБ-ууд дарамт, айлган сүрдүүлэлтэд өртөх давтамж.....	69
Зураг 39. Өнгөрсөн таван жилийн хугацаанд ИНБ-уудын оролцсон хуулийн төслүүд	70
Зураг 40. ИНБ-уудын саналыг төрийн байгууллага хүлээн авч холбогдох хуулийн төслүүдэд тусгасан байдал, сүүлийн таван жилийн байдлаар.....	70
Зураг 41. Төр засгийн шийдвэрийг эсэргүүцэх ИНБ-уудын арга замууд, сүүлийн таван жилийн байдлаар	71
Зураг 42. Төр засгийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх ИНБ-ын үр дүнтэй арга хэлбэрүүд	72
Зураг 43. Компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх ИНБ-ын арга хэлбэрүүд, сүүлийн таван жилийн байдлаар.....	72
Зураг 44. Компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэхэд ИНБ-уудын ашигладаг үр дүнтэй аргууд	73
Зураг 45. ИНБ-ын оролцоог бэхжүүлэх талаар төс засгаас хүлээж буй дэмжлэг.....	74
Зураг 46. ИНБ-ын оролцоог бэхжүүлэх талаар компаниудаас хүлээж буй дэмжлэг.....	75
Зураг 47. Хамтын ажиллагаагаа бэхжүүлэх талаар бусад ИНБ-уудаас хүлээж буй дэмжлэг	76

Хүснэгт

Хүснэгт 1. Асуумжийн нийт асуултын тоо, бүлгээр, төрлөөр	29
Хүснэгт 2. ИНБ-уудын гол анхаарлын бүс нутаг.....	33
Хүснэгт 3. ИНБ-уудын газар зүйн байршил	34
Хүснэгт 4. Уул уурхайн засаглалын чиглэлээр ажиллаж буй ИНБ-уудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл.....	42
Хүснэгт 5. ИНБ-уудын уул уурхайн засаглал дах үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн байдал	43
Хүснэгт 6. Уул уурхайн засаглалын ИНБ-уудын оролцоотой бодлогын асуудлууд.....	45
Хүснэгт 7. ИНБ-уудын төвлөрвөл зохих бодлогын чиглэлүүд.....	46
Хүснэгт 8. ИНБ-уудын ажиллавал зохих бодлогын тэргүүлэх чиглэлүүд	47
Хүснэгт 9. ИНБ-уудын ажиллахыг хүсэж бодлогын чиглэлүүд	48
Хүснэгт 10. ИНБ-уудын ажиллахыг хүссэн бодлогын тэргүүлэх чиглэлүүд.....	49
Хүснэгт 11. Иргэний нийгмийн оролцоотой, уул уурхайн засаглалтай холбоотой бодлогын асуудлын тоо	50
Хүснэгт 12. ИНБ-уудын үйл ажиллагааны хамгийн түгээмэл арга хэрэгслүүд	50
Хүснэгт 13. ИНБ-уудын үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн нь.....	52
Хүснэгт 14. ИНБ-уудын амжилттай ажилласан бодлогын чиглэлүүд	53
Хүснэгт 15. ИНБ-уудын амжилттай ажилласан бодлогын чиглэлүүдийг эрэмбэлсэн нь	54

Хураангуй

Байгалийн Баялгийн Засаглалын Хүрээлэн (ББЗХ) Австрали Монголын Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП) хүрээнд Монгол Улсын уул уурхайн салбар дах иргэний нийгмийн оролцооны орон зайн өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэх судалгааны ажлыг гүйцэтгэсэн ба үр дүнг нь энэхүү тайлангаар танилцуулж байна. Иргэний нийгэм маш олон сорилтуудтай нүүр тулж буй энэ цаг үед хийсэн эл судалгааны бас нэг зорилго нь уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг оновчтой болгоход чиглэгдсэн зөвлөмжүүдийг гаргаж, салбарын зүгээс улс орон, ард иргэдэд үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулахад оршино.

Нүүрс, зэс, алт, цайр, төмрийн хүдэрт тулгуурласан уул уурхайн салбар нь Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), экспортын орлогыг бүрдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахад чухал үүрэг гүйцэтгэдэг ч экспортын логистик, дэд бүтцийн сул хөгжил, баялгийг боловсруулалгүй түүхий эд хэлбэрээр экспортолдог, татвар хураалттай холбоотой хүндрэлүүд, байгалийн баялгийн орлогын оновчгүй удирдлагаас үүдэлтэй засгийн газрын өр зэрэг бэрхшээлүүд уг салбарт дарамт болсон хэвээр байгаа нь салбарын талаарх олон нийтийн шүүмжлэл, төр засаг, уул уурхай эрхлэгчид, иргэний нийгэм, нутгийн иргэдийн хоорондох зөрчилдөөний гол шалтгаан болж байна.

1990-ээд оноос эхлэн ардчиллын үнэ цэнэ, хүний эрх, бодлогын хэлэлцүүлгүүдийг түүчээлсээр ирсэн иргэний нийгэм нь засаглалын сорилтуудыг шийдвэрлэхэд нэн чухал үүрэгтэй. Уул уурхайн салбарын үүрэг роль өсөн нэмэгдэхийн хэрээр уул уурхайн засаглалын асуудлаар ажиллаж буй ИНБ-ын үүрэг роль ч мөн нэмэгдсэнийг Монголын Байгаль Хамгаалах Иргэний Хөдөлгөөний Эвсэл, Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөл, хариуцлагатай, ил тод байдлыг дэмжих Шилэн дансны тухай хууль зэрэг амжилттай хэрэгжиж буй олон үйл ажиллагаанаас харж болно. Хариуцлагатай уул уурхайн дадлуудыг нэвтрүүлэх, авлигын эрсдэлийг арилгах, уул уурхайн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын ил тод байдал, олон нийтийн оролцоог хангах зорилготой Хариуцлагатай уул уурхайн санаачилга (ХУУС), Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС) зэрэг санаачилгуудад ИНБ-ууд нэгдэн орсон байдаг. Гэсэн хэдий ч, дээрх санаачилгуудыг иргэний нийгмийн зүгээс идэвхийлэн дэмждэггүй, иргэний нийгмийн үр дүнтэй оролцоо, чадавх сул, ИНБ-ууд асуудалд популист байдлаар ханддаг гэх мэт шүүмжлэлүүд гарсаар байгаа нь ИНБ-уудын оролцоог улам нэмэгдүүлэх, дээрх санаачилгуудыг төр засгийн зүгээс идэвхтэй дэмжих нь чухал байгааг илтгэж байна.

КОВИД-19 цар тахалтай холбоотой хязгаарлалтуудын улмаас нэлээд хумигдаад байсан иргэний нийгмийн орон зайг хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хязгаарлах оролдлого хийгдэх боллоо. Иргэний нийгмийг нүхчин дарах санаа засгийн газрын мэдэгдлүүдэд цухалзах болсон нь аливаа хөдөлгөөнд оролцогчдыг цээрлүүлэх нь гэсэн айдсыг олны дунд төрүүлэх болов. Үүний жишээнд, уул уурхай, дэд бүтцийн салбар дах стратегийн ач холбогдолтой төслүүдийг саатуулах аливаа оролдлогыг мөрдөн шалгах засгийн газрын ажлын хэсгийг 2022 онд байгуулсныг дурдаж болно. Сүүлийн үеийн энэ мэт жишээнүүд, түүнчлэн иргэний нийгмийн үйл ажиллагааг бусдыг дарамталж мөнгө авах хэрэгсэл болсон мэтээр олон нийтийн дунд цоллох болсон нь иргэний нийгмийн орон зайг хязгаарлах оролдлого бодит эрсдэл болсныг харуулна.

Гэвч энэ мэт сорилтуудыг сөрөн, засгийн гарын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх талаар иргэний нийгэм сайн ажиллаж байгааг тусгай зөвшөөрөл олгох болон худалдан авах үйл ажиллагаа, орон нутгийг хөгжүүлэх гэрээ хэлэлцээрт гарсан олон эерэг өөрчлөлтүүд бэлхнээ илтгэнэ. Товчхондоо,

Монгол Улсын иргэний нийгэм улам өсөн нэмэгдсээр буй эрсдэл, сорилтуудын дунд олборлох салбарын засаглалд дорвитой хувь нэмэр оруулсаар ирснийг энд нэгтгэн дүгнэж байна.

Байгалийн баялгийн засаглалд хувьсал өөрчлөлтийг авчрахад хүчирхэг, мэдээлэлтэй иргэний нийгэм чухал үүрэг гүйцэтгэдэг болохыг ББЗХ онцолсоор ирсэн. Энэ үүргээ амжилттай хэрэгжүүлэхэд нь тэдний чадавхыг хөгжүүлэх, түншлэл, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, санхүүжүүлэх талаарх төр засаг, бусад оролцогч талуудын дэмжлэг нэн чухал. Байгалийн баялгийн арвин нөөцтэй улсуудад хүчирхэг иргэний нийгэмтэй байхын ач холбогдол, түүнчлэн сайн засаглалыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм хэр оновчтой нөлөөлж буйд тогтмол үнэлгээ хийх хэрэгцээ шаардлагын талаар энэ тайланд чухалчлан тэмдэглэсэн буй.

Монгол Улсын уул уурхайн салбарын засаглалд оролцогч иргэний нийгмийн байгууллагуудын (ИНБ) олон талт хэлбэрүүд, тухайлбал, үйл ажиллагааны цар хүрээ, тулгардаг сорилтууд, тэдний талаарх оролцогч талуудын байр суурь зэргийг энэхүү тайланд нарийвчлан судалсан ба зарим гол үр дүнгүүдийг энд хураангуйлав.

Монгол Улсын эдийн засгийн гол салбар болох уул уурхайн салбарын засаглалд өөр өөрийн онцлог бүхий ИНБ-үүд өөрсдийн онцгой хувь нэмрээ оруулсаар ирсэн. Энэхүү судалгаагаар эдгээр олон хэв шинжит ИНБ-үүд, тэдний уул уурхайн засаглалд оруулж буй хувь нэмрийг таниулах болно.

Юуны өмнө, ИНБ-үүд үйл ажиллагааны хэлбэр нь өнөөгийн эрх зүйн орчноор тодорхойлогдоно. Ихэнх нь төрийн бус байгууллага хэлбэрээр албан ёсоор бүртгүүлж үйл ажиллагаа явуулдаг ч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ИНБ албан ёсоор бүртгүүлэх шаардлагагүйгээр үйл ажиллагаа эрхлэх боломжтой. Үүний нэг тод жишээ нь бүртгэлгүй ТББ-үүд сүлжээ болох Монгол дах Төлсөн авснаа нийтэл эвсэл юм.

Эдгээр байгууллагуудын эрхэлдэг үйл ажиллагааны гол чиглэл нь олон нийт эсхүл идэвхтэн гишүүдийн хүсэл сонирхлын тусгал байдаг. Тэд уул уурхайн компаниудаас авахуулаад нийслэлд төвтэй бодлогын хүрээлэнгүүдийг хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг. Тэдний зарим нь зөвхөн үндэсний хэмжээний асуудалд төвлөрдөг бол бусад нь бүс нутаг, аймаг, сум дамнасан олон талт асуудлуудад анхаарлаа хандуулсан байдаг.

Улаанбаатар бол Монгол Улсын бизнес, улс төр, эдийн засгийн төв бөгөөд ихэнх ИНБ-үүд үйл ажиллагааны үндсэн талбар юм. Гэвч нэлээдгүй олон ИНБ-үүд төв оффис, эсвэл орон нутгийн салбар, түнш байгууллагаар дамжуулан хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг. Насны хувьд, он цагийг туулан 30-аад жилийг ардаа орхин хөгжиж ирсэн ИНБ-үүд зэрэгцээ, уул уурхайн засаглалд оролцоод нэг хоёрхон жил болж буй шинээр үүсээд удаагүй ИНБ-үүд ч бий. Байгууллагын хэмжээ, жендэрийн бүтцийг авч үзвэл, ИНБ-үүд ихэнх нь цаг үеэ соргоогоор мэдэрч чадсан, цомхон баг бүхий жижиг нэгж хэлбэрээр анх үүссэн ба, хүйсийн хувьд тэнцвэртэй буюу нийт ИНБ-үүд бараг тал нь эмэгтэй ажилтныг олноор ажиллуулдаг байна. Удирдах албан тушаалд нас, туршлагыг голлон харгалзах ба 35-с дээш насны туршлагатай менежерүүдээр удирдуулсан ИНБ-үүд олон байна. Түүнчлэн, эмэгтэй удирдагчтай ИНБ-үүд нэлээдгүй байгааг цохон тэмдэглэх нь зүйтэй.

ИНБ-үүд зорилго, хүсэл тэмүүлээс цааш өнгийвөл, иргэний нийгмийн салбарыг бүхэлд нь хамарсан санхүүжилтийн бэрхшээлийг харах болно. Маш бага жилийн төсөвтэй ИНБ-үүд олонх нь төсвөө яаж ийж байгаад хүргэх хүнд сорилттой нүүр тулдаг. Тэдний төсөв нь 10 сая төгрөгөөс хэтрэхгүй байх нь олонтоо бөгөөд үйл ажиллагааных нь ач холбогдлыг ойлгож мэдэрсэн олон

улсын сангууд, хувийн хэвшил болон өгөөмөр сэтгэлтэй нэгний дэмжлэгээр үйл ажиллагаагаа залгуулдаг. Олон ИНБ-ууд бусдад зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар санхүүжилт олохоос аргагүй байдалд ордгоос, өөрийн стратегийг хэрэгжүүлэхээс илүүтэйгээр бусдад зөвлөх үзүүлэхэд цаг зав, анхаарлаа хандуулахад хүрдэг ажээ. Нөгөө талаас, зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон өөрийн стратегийг хэрэгжүүлэх ажлууд хоорондоо харилцан уялдаатай, нэг нь нөгөөгөө нөхсөн шинж чанартай байж болох ч, зөвлөх үйлчилгээ эрхлэх явдал нь тухайн ИНБ-ын хувьд санхүүжилтийн эх үүсвэр дутмаг байгаагийн илрэл юм.

Нийт ИНБ-уудын ¾-с илүү нь хоорондоо хамтрах, нэг эвсэл, сүлжээнд нэгдэж орох нь өөрсдийн хүч нөлөөг нэмэгдүүлэх арга гэж үздэг ажээ. Монгол дах төлсөн авснаа нийтэл эвсэл, ОУИТБС, Монфемнет зэрэг нэрс бол ИНБ-ууд дангаараа давж үл чадах саад бэрхшээлийг нэгдэн нийлэх замаар хамтын хүчээр давах боломжийг бүрдүүлж буйн тодоос тод жишээ юм.

Уул уурхайн засаглалын гол цөм рүү нэвтрэх тусам ИНБ-уудын үйл ажиллагаа тодорхой чиглэлүүдэд, тухайлбал мэдээллийн ил тод, нээлттэй байдал, нутгийн иргэдийн ашиг сонирхол, хүрээлэн буй орчин, нийгэмд үзүүлж буй нөлөөлөл, хүний эрх, жендэр зэрэг асуудлуудад төвлөрч, олон хэлбэрээр явагдах ба тулгарч буй бэрхшээлийнхээ тусгал нь болсон байдаг (жишээлбэл, бодлогын түвшинд нөлөөллийн арга хэмжээ явуулах, оролцогч талуудыг оролцоог хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, ил тод байдлыг дэмжих кампанит ажлуудыг зохион байгуулах, мэдээллийг стратегийн зорилгоор ашиглах, бодлогын судалгаа хийх зэрэг).

Монгол Улс дах уул уурхайн засаглалын олон хэв шинжээс хамааран, ИНБ-ууд харилцан адилгүй асуудлуудад гол анхаарлаа хандуулдаг. Тэдний дийлэнх нь орон нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулах, хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах, байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн нөлөөллийг судлан тогтоох ажилд голлон анхаардаг бол авлигатай тэмцэх, орлогын удирдлага зэрэг илүү төвөгтэй асуудлууд нь нарийн мэргэших шаардлага гардаг тул эдгээр чиглэлээр тун цөөн тооны ИНБ-ууд ажилладаг байна. Тэргүүлэх чиглэлүүдийг нарийвчлан судалж эрэмбэлснээс харвал байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн нөлөөлөл хамгийн чухалд тооцогдсон ба, хүний эрх, жендэрийн бодлого, мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдлын асуудлуудыг хоёрдугаарт эрэмбэлсэн байна. ИНБ-уудын сонирхлыг хамгийн ихээр татаж буй асуудлаар эрчим хүчний шилжилт нэрлэгдсэн нь энэ чиглэлээр чадавхыг хөгжүүлэх, санхүүжилтийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага өндөр байгааг илтгэнэ. Тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлохоос гадна, ИНБ-ууд эрчим хүчний шилжилт, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн салбар дах ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын хэм хэмжээ, авлигатай тэмцэх чиглэлээр ажиллах сонирхолтой байгаагаа тус тус илэрхийлсэн байна.

Чадавхаа хөгжүүлэх, нарийн мэргэших асуудал олон ИНБ-уудын хувьд тулгамдсан асуудал болоод байна. Хэт олон асуудалтай тулгардаг тэдэнд хэд хэдэн асуудалд нэгэн зэрэг анхаарал хандуулах шаардлага гардаг нь хэвийн үзэгдэл юм. Ихэнхдээ тэдгээр шаардлага нь энгийн нэг сонголтын асуудал биш, тулгарсан сорилтуудыг (тухайлбал, санхүүжилтийн дутмаг байдал) даван туулах тэмцэл, стратегийн нэг хэсэг нь байх нь олонтоо. ИНБ-ууд олон эх үүсвэрээс жижиг дэмжлэг авах, хандивлагч болон олон улсын байгууллагуудын шаардлагад нийцсэн жижиг төсөл боловсруулан санхүүжилт босгож өөрсдийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх замаар оршин тогтнох нь олонтоо. Үйл ажиллагааны арга хэлбэрийн хувьд, бодлогын түвшинд нөлөөллийн арга хэмжээ, хэлэлцүүлэг явуулах, оролцогч талуудыг төлөөлөх, тэдэнтэй хамтран ажиллах үндсэн хоёр хэлбэр зонхилдог ба, өнгөрсөн гурван жилийн хугацаанд ИНБ-уудын хамгийн түгээмэл, үр дүнтэй байдлаар хэрэгжүүлсэн

үйл ажиллагаанууд энд дурдсан зонхилох хоёр чиглэлд хамаарч байна. Харин, нийтийн эрх ашгийг өмгөөлөх чиглэлээр маш бага үйл ажиллагаа явуулсан нь эл үйл ажиллагаа зохих үр чадвар, мэргэшил шаарддагтай холбоотой. Эх үүсвэр, үр чадварын дутмаг байдал нь энэ хэлбэрийн үйл ажиллагаа явуулахад тулгардаг саад тотгор болдог ба, үүнийг даван туулсан нөхцөлд амжилтад хүрэх бүрэн боломжтойг зарим нэг ИНБ-уудын жишээнээс тод харж болно.

ИНБ-уудын хамгийн түгээмэл эрхэлдэг үйл ажиллагаа нь бодлогын түвшний нөлөөлөл, хэлэлцүүлэг хийх, удаах байранд оролцогч талуудтай хамтран ажиллах, оролцох хэлбэр орно. Харин, нийтийн эрх ашгийг өмгөөлөх, өгөгдөл ашиглах ба бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх ажлыг зориглон оролдох байгууллага тун цөөн байдаг нь түүнд шаардагдах чиглэлээр нарийн мэргэшээгүй, эх үүсвэр хангалтгүй байдагтай шууд холбоотой байна.

Олон нийтийн оролцоо нь нэлээд ИНБ-уудад ихээхэн дэмжлэг болдог. Олон талт төвөгтэй асуудалтай тулсан үед түүнийг шийдвэрлэж, зорилгодоо хүрэхийн тулд ИНБ-ууд үйл ажиллагаандаа олон нийтийг татан оролцуулахыг чухалчилна. Олон нийтийг бусадтай холбох гүүр болохынхоо хувиар, ИНБ-ууд олон нийтийн оролцоог хангаж, хамтран ажиллах, хуваалцах замаар уул уурхайн засаглалд тулгарсан сорилтуудыг даван туулахад түсэлж чадна.

ИНБ-уудын зорилгодоо хүрэх үндсэн арга хэрэгсэл бол хамтын ажиллагаа, оролцоо, түншлэл юм. ИНБ-уудын гол хамтрагчид нь бусад ИНБ-ууд, төрийн байгууллагууд, хандивлагч болон олон улсын байгууллагууд, нутгийн иргэд байдаг. Сүүлийн үед бас нэгэн чухал хамтрагч гарч ирсэн нь уул уурхайн компаниуд байлаа. Ийнхүү, уул уурхайн салбар дах иргэний нийгэм хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд гарах үүд хаалга нээгдсэн юм. Үүнд ОУИТБС, ХУУС чухал үүрэг гүйцэтгэснийг дурдах ёстой. Түүнчлэн, төрийн байгууллага, сэтгүүлчидтэй ажиллах хамтын ажиллагаандаа ИНБ-ууд төдийлөн ам сайтай байдаггүйг хэлэх нь зүйтэй. ИНБ-ууд төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа сайжруулахыг хүсдэг ба албан хаагчдын халаа солио их, хамтын ажиллагаа тогтворгүй, илэн далангүй байдал дутмаг зэрэг нь тэдэнтэй хамтран ажиллахад гол саад тотгор болдгийг дурджээ.

Мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан хэдий ч, ИНБ-ууд уул уурхайн компаниудын хоорондын харилцаа бэрхшээлтэй тулсан хэвээр байна. Тодруулбал, гадаадын хөрөнгө оруулалттай эсхүл том компаниуд илүү нээлттэй, харьцахад хялбар байдаг бол, Монгол эзэнтэй, уул уурхайн жижиг компаниуд ИНБ-уудын хувьд хаалттай, харилцах сонирхолгүй байдаг нь тэднийг боломжит хамтрагч гэхээс илүүтэйгээр дайсагнагч этгээд гэж үздэгтэй нь холбоотой. Үзэл бодлын энэ ялгаа нь уул уурхайн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хамгийн том бэрхшээл болдог ажээ.

ИНБ нь төрийн байгууллагуудтай олон нийтийг хамарсан хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалт, нүүр тулсан уулзалт, цахим хуудсаар дамжуулан санал бодлоо солилцдог бол уул уурхайн компаниудтай олон талт оролцогч талуудын уулзалт, албан ёсны цахим хуудас, нүүр тулсан уулзалт хэлбэрээр харьцана. ИНБ хоорондын харилцаанд олон нийтийн хэлэлцүүлэг, нүүр тулсан уулзалт, цахим шуудан голлох ч, уламжлалт харилцааны өөр бусад олон хэлбэрүүд түгээмэл ашиглагдана.

Сорилтуудын зэрэгцээ, хөгжил дэвшлийн түүчээ болсон хамтын ажиллагааны өргөн боломж байна. Хандивлагчид, олон улсын байгууллагууд, бусад ИНБ-ууд, уул уурхайн компаниуд, төрийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх сонирхол ИНБ-уудад өндөр байна. Хандивлагчдын санхүүжилт ИНБ-уудад амин чухал дэмжлэг болдог ч, хандивлагчийн тэргүүлэх

чиглэлд өөрчлөлт гарах, эсвэл төсөл дуусмагц санхүүжилт зогсдог тул ИНБ-уудад шинэ нөхцөл байдалд дасан зохицох, алсын хараатай байх шаардлага зүй ёсоор тулгарна.

Бодлогын тодорхой чиглэлүүд, тухайлбал байгаль орчин, нийгэмд уул уурхайн үзүүлэх нөлөөлөл, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, эрчим хүчний шилжилт, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар хамтран ажиллах хүсэл сонирхол ИНБ-уудад их байгаа нь бодлого, засаглалд нөлөөлөх хамтын хүсэл эрмэлзлэлийн тусгал болохын зэрэгцээ, байнга хувьсан өөрчлөгдөж буй Монгол орны уул уурхайн салбарт хариуцлагатай дадлуудыг төлөвшүүлэхэд чухал түлхэц болох юм.

Цаашлаад, уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайг хамгаалах, бэхжүүлэхэд дан ганц ИНБ-уудын хүчин чармайлт хангалтгүй. ИНБ-уудын зүгээс төрийн байгууллагуудад тавьсан хүсэлтүүдийн эхэнд мэдээллийн хүртээмж, мэдээлэл авах боломжийг сайжруулах асуудал тавигдсан байдаг бөгөөд, өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн чадавхжуулах дэмжлэг хэрэгтэй байгаа тухайгаа дурдсан байдаг. Түүнчлэн, оролцооны талбаруудыг бий болгох асуудлыг чухалчлан тавьсан ба тэдгээрийн хүрээнд төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагуудыг тодорхой заах, ОУИТБС зэрэг одоо байгаа талбаруудыг дахин сэргээхийг уриалсаар иржээ. Тавьсан санал хүсэлт, нэхэмжлэлд хариу өгдөггүй, нээлттэй бус хэмээх шүүмжлэл төрийн байгууллагуудыг байнга дагадаг. ИНБ-уудыг албан ёсны ажлын хэсэг, зөвлөлд оруулах нь үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох чухал хөшүүрэг мөн хэдий ч ИНБ-уудыг зохицуулсан хууль тогтоомжийг өөрчлөх асуудалд төр засгийн зүгээс түн болгоомжтой, хойрго хандсан хэвээр байна. ИНБ-уудын зүгээс иргэний нийгэмд үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэхийн тулд нийгмийн даатгал, татварын зохицуулалтыг эргэж харах, шүгэл үлээгчийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг баталгаажуулах хууль тогтоомжийг бий болгох хэрэгтэй.

Байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тогтмол тайлагнаж байхыг ИНБ-ууд уул уурхайн компаниудаас хүлээдэг. Орон нутгийн түвшинд гардаг зөрчилдөөнийг шийдвэрлэх механизмыг бий болгох нь эн тэргүүний зорилт бөгөөд, тогтмол үүлзалт зохион байгуулах, салбарын гаргасан санаачилгад оролцох замаар талуудын хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхийг хөхиүлэн дэмждэг. Хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгод ХУУС, ОУИТБС зэрэг төрөл бүрийн талбаруудыг үр дүнтэй ашиглах нь чухал байна.

ИНБ-ууд өөр хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хамтран ажиллах, чадавхаа сайжруулах, олон улсын сүлжээнд элсэх шаардлагатай ба, нөлөөллөө нэмэгдүүлэхийн тулд хамтарч төсөл хэрэгжүүлэх ёстой гэж ИНБ-ууд үздэг. Харилцааны стратеги, үйл ажиллагаагаа сурталчлан таниулах нь ИНБ-ын хувьд амин чухал бол, гол асуудал дээр нэгдмэл байр суурьтай байх нь ИНБ-уудын хувьд чухал асуудал юм. Түүнээс дутуугүй чухал асуудал бол хүрсэн амжилтаа хэмжигдэхүйц, харагдахуйц байдлаар баримтжуулах явдал юм. ИНБ-ууд ил тод, хариуцлагатай байдлын зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох ёстой ба, номлодог зүйлээ өөрөө хэрэгжүүлдэг байх нь чухал.

ИНБ-ууд хэвлэл мэдээллийн салбартай хамтран ажиллахыг эрмэлзэх нь зүйтэй ба мэдээллийн энэ эринтэй дасан зохицох, байнга хувьсан өөрчлөгдөж байдаг орон зайд харилцааны стратегиа өөрчлөх нь чухал байдаг.

Уул уурхайн засаглалд оролцогч ИНБ-уудын дунд хийсэн судалгааны үр дүнд дараах зөвлөмжүүдийг гаргалаа:

1. Төр засгийн дэмжлэг:

- Уул уурхайн салбарт ажиллаж буй иргэний нийгмийг дэмжих тодорхой, нарийвчилсан стратеги боловсруулах.
- ОУИТБС, НЗТ зэрэг олон болон хоёр талт санаачилгуудыг манлайлах.
- Бодлогын шийдвэр гаргахад иргэний нийгмийг оролцуулах талаар зөвхөн зөвлөмж гаргах бус бодит арга хэмжээ авах.
- Иргэний нийгэмтэй хамтран бодлого боловсруулах боломжуудыг эрэлхийлэх, засаглалын асуудлаарх тэдний байр суурийг анхаарч үзэх.
- ИНБ-уудын бие даасан байдалд халдалгүйгээр тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.
- Татвар, нийгмийн даатгалын хөнгөлөлтөөр дамжуулан ИНБ-уудад тулгардаг санхүү, хууль тогтоомжтой холбоотой дарамтыг бууруулах.
- Мэдээллийн чанар, соргог байдлыг хангах, нээлттэй мэдээллийн шалгуурыг хэрэгжүүлэх замаар мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах.

2. Уул уурхайн компаниудын оролцоо:

- Иргэний нийгэмтэй үр дүнтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх харилцаа, оролцооны тогтвортой стратегийг боловсруулах.
- ИНБ-уудтай яриа хэлэлцэл, түншлэлийг хөгжүүлэх санал санаачилга хөхиүлэн дэмжих.
- ОУИТБС зэрэг санаачилгуудыг идэвхтэй дэмжих, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциациас гаргасан Хариуцлагатай уул уурхайн хөтөлбөрийг дэмжих, бусад ИНБ-уудын дунд сурталчлан таниулах.
- Ил тод байдлыг дэмжих ажлын хүрээнд, өөрийн хэрэгжүүлж буй төслүүдийн талаар иргэний нийгмийг мэдээллээр хангах.
- Иргэний нийгэмтэй яриа хэлэлцэл хийх сүвгуудыг нээлттэй байлгах, хуулийн хүрээнд ажилладаг ИНБ-уудыг түр зуурын, ашиг хонжоо харсан ИНБ-уудаас ялгаж салгах.
- ИНБ-уудыг, ялангуяа хамтын ашиг сонирхол бүхий асуудлын (тухайлбал, уул уурхайн салбар дах эрчим хүчний шилжилтийн нөлөөллийг бууруулах) хүрээнд, өөрчлөлт шинэчлэлийн хамтрагч гэж үзэх.

3. Иргэний нийгмийн ажиллах орчныг нэмэгдүүлэх:

- Уул уурхайн салбарын хувьсал өөрчлөлт, технологийн дэвшилтэй хөл нийлүүлэхийн тулд чадавхаа хөгжүүлэх, суралцах үйл ажиллагааг эрхэм зорилгоо болгох.
- Чадавх хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлсны дагуу чадавх бэхжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, эрчим хүчний шилжилт, мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг чухал эрэлттэй чадавхыг хөгжүүлэх ажлыг төлөвлөгөөнд тусгах.

- Санхүүжилт босгох, стратеги удирдлагыг сайжруулахад гол анхаарал хандуулах замаар орчны өөрчлөлтөд дасан зохицох арга хэмжээ авах.
- Бусад оролцогч талуудтай хамтын ажиллагаа, түншлэлийг эрчимжүүлэх, хамтын ажиллагааны шинэлэг арга хэлбэрүүдийг эрэлхийлэх.
- ОУИТБС-ыг шинэчлэн өөрчлөх ажлыг санаачлан эхлүүлэх, ОУИТБС-ын стандартыг чанд дагаж мөрдөх, иргэний нийгмийг чадавхжуулах, хамгаалах зорилгод уг талбарыг үр дүнтэй ашиглах.
- Иргэний нийгмийн орон зайг тогтмол үнэлэх, иргэний нийгмийн идэвхтнүүдийг хамгаалах стратеги боловсруулах.
- Иргэний нийгмийн идэвхтнүүдийг дарамталсан, хавчсан, нэр төрийг гутаан доромжилсон тохиолдлуудыг бүртгэх, онцгой тохиолдолд тэдэнд туслах зорилгоор хөрөнгө босгох, эрх зүйн тусламж үзүүлэх стратеги боловсруулах.
- ОУИТБС, НЗТ болон оролцооны бусад талбаруудын дүрэм журамд иргэний нийгмийг хамгаалсан зүйл заалт оруулах талаар нөлөөллийн ажил явуулах.

Энэ зөвлөмжийн гол зорилго нь Монгол Улсад хариуцлагатай уул уурхайн дадлуудыг төлөвшүүлэхэд иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг, нөлөөллийг бэхжүүлэхэд оршино. Үүнд, ИНБ-уудтай хамтран ажиллах, төр засаг, уул уурхайн компаниудын дэмжлэг, ИНБ-уудын ажиллах орчныг нэмэгдүүлж, сорилтуудыг даван туулах чадварыг бий болгох нь чухал үүрэгтэй.



1. Монгол Улс дах иргэний нийгмийн орон зай ба уул уурхайн танилцуулга

1.1. Оршил

1.1.1. Олон сорилттой тулсан, эдийн засгийн гол салбар

Монгол Улсын эдийн засгийн гол салбар нь уул уурхай гэвэл огтхон ч хэтрүүлэг болохгүй. Нийт 17.1 тэрбум ам.доллараар тооцогдох ДНБ-ний 23 хувь, 2022 оны нийт 12.5 тэрбум ам.долларын экспортын орлогын 84 хувийг дангаар бүрдүүлсэн¹ уг салбар 2023 оны эхний 10 сарын байдлаар улсын төсөвт 1.9 тэрбум ам.доллар төвлөрүүлжээ.² Түүнчлэн, 28.5 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалтын 75 хувийг (2022 оны эцсийн байдлаар) дангаар бүрдүүлсэн ба мөн онд Монгол Улсад 3.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шинээр орсны 82.5 хувь нь зөвхөн уг салбарт оржээ.³ Уг салбарт нийт ажиллах хүчний багахан хэсэг буюу 5 орчим хувь ажилладаг хэдий ч, дундаж цалингийн хэмжээ улсын дунджаас 2.4 дахин өндөр байдаг.⁴ Орон нутагт ажлын байр бий болгох, үйлдвэрлэгчдэд бизнесийн боломж олгох зэргээр уул уурхайн том компаниуд орон нутгийн эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулдаг.

Улсын төсвийн орлогын дийлэнхийг бүрдүүлдэг уул уурхайн гол бүтээгдэхүүнийг нүүрс, зэсийн баяжмал, алт, цайр, төмрийн хүдэр эзэлнэ. 2023 оны эхний 10 сарын байдлаар Монгол Улс 64 сая тонн нүүрс, 1.2 сая тонн зэсийн баяжмал, 4.6 мянган тонн молибден, 12.5 тонн алт, 4.6 сая тонн төмрийн хүдэр, 2 сая тонн төмрийн хүдрийн баяжмал олборлоод байна. Мөн хугацаанд, 4.2 сая баррель түүхий газрын тос олборлосон нь алтны салбартай дүйцэхүйц орлогыг бий болгожээ.⁵

Салбарын бодлогыг, ББЗХ-ийн боловсруулсан Байгалийн баялгийн тунхагт энгийнээр тайлбарласан байдаг.⁶ Уг тунхагт, олборлох салбарын бодлогыг, шийдвэрийн хэлхээгээр дамжуулан тодорхойлжээ (Зураг 1). Улс орны гаргах эхний шийдвэрүүд нь газрын доорх баялгийг нээн илрүүлэх, улмаар хайгуул хийх, олборлох ажлыг зөв зохион байгуулахад чиглэгдэнэ. Энэ шатанд, шинэ ордыг ашигласнаар улс орны эдийн засаг, байгаль орчин, нийгэм, засаглалд ямар үр дагавар гарч болохоос хамаарч шийдвэр гарна. Дараагийн шатанд буюу ордыг ашиглахаар шийдсэн тохиолдолд уг баялаг улс орон, хүн ардад үр өгөөжтэй байх явдлыг хангана. Үүнд, татварын зөв тогтолцоог бий болгох, уул уурхайгаас орон нутгийн эдийн засаг, хүн амд очих үр өгөөжийг баталгаажуулах, үндэсний өмчит баялгийн компаниудыг байгуулж (энэ нь олборлох үйлдвэрлэлд чухал үүрэг гүйцэтгэж, улс оронд үлдэх үр өгөөжийг дээд зэргээр нэмэгдүүлнэ) ажиллуулна. Татвар, хураамжуудыг төвлөрүүлсний дараа, орлогыг хүн амын бүлгүүд, одоо болон хойч үедээ шударга хуваарилах, бараа бүтээгдэхүүний үнэ, зах зээлтэй холбоотой эдийн засгийн тогтворгүй байдлаас хамгаалах зорилгоор оновчтой удирдах асуудал гарч ирнэ. Эцэст нь, хэзээ нэгэн цагт шавхагдах нь зайлшгүй түл баялгийн орлогыг хойч үедээ хадгалан өвлүүлэх, эрч хүчтэй хувийн хэвшилд суурилсан хүчирхэг, төрөлжсөн эдийн засгийг хөгжүүлэхэд ашиглах зэргээр урт хугацааны үр өгөөжийг бий болгохын тулд ухаалаг зарцуулах нь юунаас чухал. Энэ бүх үе шатны шийдвэрүүд

¹ Үндэсний Статистикийн Хороо, “Үндэсний тооцоо”

² Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, “Эрдэс баялгийн салбарын статистик-2023 оны эхний 10 сар”

³ Монгол банк “Гадаад секторын статистик”


⁴ Үндэсний Статистикийн Хороо, “Үндэсний тооцоо”

⁵ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам “Эрдэс баялгийн салбарын статистик-2023 оны эхний 10 сар”

⁶ ББЗХ, “Байгалийн баялгийн тунхаг (Хоёрдох хувилбар).”

хоорондоо холбоотой тул аль нэг дээр нь алдаж гэмээнэ улс орон тавьсан зорилго, хүлээсэн үр дүндээ хүрэх боломжгүй болдог. Иймд эдгээр бүх үе шатанд шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ил тод, хариуцлагатай байдлыг бодлогын хүрээнд дээд зэргээр хангах арга хэмжээг төр засгийн зүгээс авах хэрэгтэй.

Зураг 1. Байгалийн баялгийн тунхаг дах шийдвэрийн хэлхээ



Монгол Улсын уул уурхайн салбарыг дээрх тодорхойлолтын дагуу товчхон дүрсэлснийг доор үзүүлэв. Компаниуд уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхийн тулд засгийн газраас тусгай зөвшөөрөл авна. Одоогоор, 1,718 олборлолтын, 983 хайгуулын, нийт 2,701 хүчинтэй тусгай зөвшөөрөл бий. Тусгай зөвшөөрөл эзэмшдэг 1,724 компани байгаагийн 23.9 хувь нь гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай, үлдэх хувь нь дотоодын компаниуд байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын 33.6 хувь нь Хятад, 23.4 хувь нь Сингапур, 20 хувь нь Канад, үлдэх хувь нь өөр улсуудаас, ялангуяа нэлээд олон нь оффшор бүсээс гаралтай байна.⁷

Зарим орд газруудад стратегийн орд газар гэх статусыг хуулиар олгосон байдаг. Одоогоор, ийм статустай, ашиглагдаж байгаа болон ашиглагдаагүй 16 орд газар байна. Эдгээр ордыг ашиглахад төр давуу эрхтэй оролцдог. Түүнээс гадна, олон тооны стратегийн бус ордыг төрийн өмчит компаниуд эзэмшдэг. Салбарын хэмжээнд төрийн өмчит компаниуд ноёлох байр суур эзлэх ба хувийн том компаниудтай мөр зэрэгцэн оршино.

Төрийн өмчит уул уурхайн гол компаниудыг Эрдэнэс Монгол компани нэгтгэн удирдах ба тэдгээрт зэс, молибдений баяжмал үйлдвэрлэгч Эрдэнэт, Хятад руу коксжих нүүрсний гол экспортлогч болох Эрдэнэс Таван Толгой, дотоодын дулааны станцуудыг нүүрсээр хангадаг Багануур, Шивээ овоо компаниуд багтана. Эрдэнэс Монгол нь Монгол орны хамгийн том зэс, алтны орд болох Оюу Толгойд цөөнхийн хувьцаа эзэмшдэг. Уг ордны менежментийг Рио Тинто компани хариуцдаг.

Мөн салбарт, нүүрс, алт олборлогч, гадаадын хамтарсан хөрөнгө оруулалттай Энержи Ресурс, дотоодын хөрөнгө оруулалттай МАК, нүүрс олборлон экспортолдог, Хятадын хөрөнгө оруулалттай МонЭнКо тэргүүтэй олон тооны хувийн хэвшлийн компаниуд үйл ажиллагаа явуулдаг. Газрын тосны салбарт ПетроЧайна компани түүхий нефть олборлон Хятад руу экспортолдог.

⁷ Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлэл, 2023 оны 11 сар.

Монгол Улс алтнаас бусад уул уурхайн бүтээгдэхүүнийхээ дийлэнхийг хөрш Хятадад экспортолдог. Алтыг харин бусад орнуудад ч гаргадаг. Зөвхөн ганц зах зээлээс хамааралтай байдал нь уул уурхайн бүтээгдэхүүний экспортын үнэнд таагүй нөлөөлдөг ч, зах зээлд ойр байрлал нь тээврийн зардлыг бууруулж, Хятадын зах зээл дэх Монголын нүүрс, бусад эрдэс баялгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг. Гэсэн хэдий ч, логистик, дэд бүтцийн сул хөгжил, төмөр зам, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал муугаас экспортын уг харьцангуй давуу талаа бүрэн ашиглаж чаддаггүй. Экспортын нүүрсний дийлэнх хэсгийг хүнд даацын автомашинаар тээвэрлэдэг нь Ковид цар тахалтай холбоотой хязгаарлалтын арга хэмжээнд өртөж саатсан бөгөөд хэрэв төмөр замаар тээвэрлэдэг байсан бол уг саатлаас бүрэн сэргийлэх боломжтой байсан.

Монгол Улс ашигт малтмалынхаа ихэнхийг түүхийгээр нь экспортолдог, боловсруулах үйл ажиллагаа зөвхөн Хятадад явагддагаас баялгийнхаа үр шимийг бүрэн хүртэж чадахгүй байна гэсэн шүүмжлэл гардаг. Боловсруулалтыг дотооддоо хийх, өртөг шингээсэн бүтээгдэхүүн экспортлох салбарын бодлого гараад олон жил өнгөрсөн ч нүүрс, газрын тос зэрэг шатах ашигт малтмалаа боловсруулалгүй түүхийгээр экспортолсоор байгаа нь дэлхий дахинд эрчим хүчний шилжилт эрчимжиж буй энэ үед Монгол Улсын олборлох салбарын хөгжил, экспортын ашигт малтмалын бүтцэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулна. Эрчим хүчний шилжилтэд шаардагдах, эрэлт нь өсөн нэмэгдсээр буй ашигт малтмалын өртгийн сүлжээнд томоохон тоглогч болох найдлагатай орнуудын нэг нь Монгол Улс юм.

Ашигт малтмалаар баялаг орнууд олборлогч компаниудаас татвар, хураамж цуглуулах замаар уул уурхайн салбараас үр шим хүртдэг. Монгол Улс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, аж ахуйн нэгжийн орлогын татвар, уул уурхайн компанийн төрийн хувь эзэмшилд ногдох ногдол ашиг, түүнчлэн гааль, нэмүү өртгийн татвар зэрэг татварын арга хэрэгслүүдийг ашиглан улсын төсвөө бүрдүүлнэ. Татвар хураах үүргийг Татварын ерөнхий газар, гааль, ашигт малтмалын газартай хамтран хэрэгжүүлнэ. Олборлох салбарын даяарчлагдсан байдал татвар хураалтад тодорхой хүндрэл үүсгэдэг нь уул уурхайн компаниуд гаднын этгээдийн шууд, эсвэл оффшор бүсэд бүртгэлтэй түүний төлөөлөл, дундын зуучлагчийн эзэмшилд байдагтай холбоотой. Товчхондоо, татвар хураалтын асуудал төр засаг, компаниудын хоорондох гол хэрүүлийн алим, авлига үүсэх нэг эх сурвалж болдог. Татварын асуудлыг ихэвчлэн татварын хуулиар зохицуулах ч, Оюу Толгой зэрэг зарим төслүүдийн хувьд татварыг төр, хувийн хэвшлийн хооронд байгуулсан хөрөнгө оруулалтын түсгай гэрээгээр зохицуулна. Бусад нөхцөлд, татварын хэмжээг тодорхой хугацаанд тогтвортой байлгаж, хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор түүнд тогтворжуулах гэрчилгээ олгодог.

Уул уурхайн компаниудаас хураасан татварын орлогыг засгийн газар захиран зарцуулна. Орлого, үнийн тогтворгүй байдал, орлогын нэг удаагийн чанар, тогтсон хэмжээнээс давсан орлого олдог, бусад салбартай харьцуулбал үлэмж давуу орлого бүрдүүлдэг зэрэг олборлох салбарын онцлогоос шалтгаалан, орлогыг буруу удирдсаны үр үршиг ганц салбараар үл тогтоно. Байгаль орчин, нийгэмд үзүүлсэн уул уурхайн сөрөг нөлөөллийн нөхөн төлбөрийг уул уурхайн бүс нутгуудад олгох, мөн ядуу бүс нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор уул уурхайн орлогыг үр дүнтэй хуваарилах хэрэгтэй. Уул уурхайн орлого өссөн ч Монгол Улсын засгийн газрын өр өндөр хэвээр байгаа нь төсвийн бодлого оновчгүй, санхүүгийн сахилга бат сул байгааг илтгэнэ. Мөн, уул уурхайн орлогоос хойч үедээ

хадгалан үлдээх үүргээ биелүүлээгүй буюу өнгөрсөн 20 жилийн хугацаанд уул уурхайгаас орж ирсэн орлогын доллар тутмаас дөнгөж ганц центийг хойч үед зориулан хадгалжээ.⁸

Өртгийн сүлжээний үе шат бүрд тулгардаг олон бэрхшээлийн улмаас Монгол Улсын уул уурхайн салбар уул уурхайн компани, нутгийн иргэд хоорондын зөрчил, улс төрийн популизм, авлигын талбар болжээ. Байгаль хамгааллаас эхлээд нутгийн иргэдэд эдийн засгийн үр өгөөжгүй (бодогдсон болон бодит) байгаа тухай гомдол хүртэл өргөн хүрээний асуудлаарх зөрчлүүд уул уурхайн компани, нутгийн иргэдийн хооронд олонтоо гарч олон нийтийг анхаарлыг татсан. Тухайлбал, ураны хайгуул, олборлолтой холбоотой үс, хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд учрах эрсдэлээс үүдэн, Францын Орано, Монголын Эрдэнэс Монголын хамтарсан Бадрах Энержи компанийг эсэргүүцсэн Дорноговь аймгийн нутгийн иргэдийн хөдөлгөөн уг төслийн олборлолтын ажлыг эхлэх хугацааг саатуулсан; нийгэм, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх маргааны улмаас, иргэний нийгэм Олон Улсын Санхүүгийн Корпорацийн зарга шүүгчид хандан Рио Тинтогийн Оюу Толгой төслийн эсрэг гомдол гаргасан; нутгийн малчдын удаан үргэлжилсэн, ширүүн тэмцлийн улмаас Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс компани Баянхонгор аймаг дахь алтны төслөө эхлэхийн тулд хамтрагч түншээ солиход хүрсэн; Аспайр майнинг, “уул уурхайгүй бүс” гэж зарласан Хөвсгөл аймагт нүүрс олборлохын тулд нутгийн иргэдийг олон жил ятгасан зэргээр энэ жагсаалт цааш үргэлжилнэ. Голдуу Улсын их хурлын сонгуулийн өмнө улс төрчид уул уурхайн компаниудыг шүүмжилж, популист гэж нэрлэгдэхээр амлалтуудыг өгдөг. Жишээ нь, уул уурхайн компаниудаас бэлэн мөнгө, хувьцаа хэлбэрээр ард түмэнд ногдол ашиг тараах амлалт улс төрийн намуудын янз бүрийн нэр, багийн цаана нуусан мөрийн хөтөлбөрт нь тусгагдсан байдаг. Өндөр албан тушаалтнууд оролцсон уул уурхайн салбар дахь авлигын хэрэг тогтмол гарч, хүн цочрохоо байсан ба хариуцлага хүлээдэггүй, хөнгөн шийтгэл аваад мултардаг нь ёс болжээ. Төрийн өмчит нүүрсний компаниудаар дамжуулан нүүрс, бэлэн мөнгө хулгайлсан гэгдэх “нүүрсний хулгайн” хэрэг ард түмнийг тэмцэлд босгож, эрүүгийн хэрэг үүсгэх, парламентын сонголт хийхэд хүргэж төрийн өмчит уул уурхайн компанийн нэлээд удирдлагууд авлигын хэргээр шоронд оров. Тусгай зөвшөөрөл олгох, гэрээ байгуулахдаа эрх мэдлээ хэтрүүлсэн хэрэгт өндөр албан тушаалтнууд мөн л холбогдсон. Тухайлбал, Оюу Толгойн Дубайн гэрээ. Уг төслийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурахдаа эрх мэдлээ хэтрүүлсэн гэж буруутгагдсан хуучин ерөнхий сайд шүүх хурал шударга байж чадахгүй, улс төрийн өшөө хонзонгоос айж байна гэсэн шалтгаар олон жил гадаадад амьдарч байна. Товчхондоо, засаглалын олон, хүнд сорилтууд олборлох салбарт тулгарч буй бөгөөд засгийн газар тэдгээрийг шийдвэрлэх оролдлогууд ихэнхдээ бүтэлгүйтэж байна.

Ийм нөхцөлд, ИНБ-үүд салбарын засаглалд маш чухал үүрэг гүйцэтгэж чадна. Өртгийн сүлжээнд тулгарах олон бэрхшээлийг шийдвэрлэх гарц нь ИНБ-үүд байж болно. Монгол Улсын олборлох салбарт гүйцэтгэсэн иргэний нийгмийн үүргийг дараагийн хэсгээс үзнэ үү.


1.1.2. Эрч хүчтэй ч, хязгаарлагдмал иргэний нийгмийн орчин

Иргэний нийгмийн эрүүл орчин буюу чөлөөт, дэмжигч орчин бүхий эрч хүчтэй иргэний нийгэм олборлох салбарын олон сорилтуудыг дангаар шийдвэрлэж чадахгүй ч, тэдгээрийг үр дүнтэй шийдвэрлэх угтвар нөхцөл юм. Ардчилсан нийгмийн гол элемент болох иргэний нийгэм үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, засаглалд оролцох, мэдээлэл авах зэрэг хүний суурь эрхийг хангахад чухал үүрэгтэй. Хүний суурь эрх, төрийн бус байгууллагыг дэмжихээ төр засаг амлаж, ардчилсан шинэчлэл эхэлсэн 1990-ээд оноос иргэний нийгэм Монголд хөгжиж эхэлжээ. 1992 оны

⁸ Дэлхийн банк “Монголын хөгжлийг хурдасгахын тулд уул уурхайгаас оюун ухаанд түшиглэх шаардлагатай”

шинэ үндсэн хуулиар олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс олон нийт, хувийн эрх ашиг, итгэл үнэмшлийн дагуу эвсэн нэгдэх эрхийг баталгаажуулав.⁹ Төрийн бус байгууллагаар дамжуулан нийгмийн амьдралд оролцох үндсэн хуулиар олгогдсон иргэний эрхийг 1997 онд баталсан Төрийн бус байгууллагын тухай хуулиар улам бататгажээ. Өдгөө, иргэний нийгэм нь албан болон албан бус байгууллагаар дамжуулан Монгол Улсын нийгмийн амьдралын бүхий л салбарт оролцогч, бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлын салшгүй нэг хэсэг болжээ. Монгол Улсад бүртгэгдсэн ТББ-уудын тоог нийт бүртгэлтэй хуулийн этгээдийн тоотой харьцуулсныг Зураг 2-т үзүүлэв. Ихэнх иргэний нийгмийн хөдөлгөөнүүд улсын бүртгэлтэй ТББ-уудаар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг.

Зураг 2. Бүртгэлтэй ТББ болон бусад хуулийн этгээдийн хувьсал



Эх сурвалж: YCX, 1212.mn

2022 оны байдлаар, улсын бүртгэлтэй 35,312 ТББ байсны дөнгөж 18 хувь буюу 6,380 ТББ үйл ажиллагаа явуулж байжээ.¹⁰ Үүнээс харахад, ТББ-ын үйл ажиллагаа явуулдаг орчин нь бүртгэлийн тоотой харьцуулахад төдийлөн таатай бус байдаг бололтой.

ТББ-ыг зохицуулдаг Монгол Улсын хуульд гишүүддээ үйлчилдэг, олон нийтэд үйлчилдэг гэсэн хоёр төрлийн ТББ байхаар заасан нь ИНБ-уудад үзүүлэх дэмжлэг, тайлагнах журам, үйл ажиллагаа, санхүүжилтийн хэлбэрт ялгаатай байдал үүсгэдэг. Салбарын мэргэжлийн холбоод, лобби бүлгүүд бүгд ТББ хэлбэрээр бүртгэгддэг, иргэний нийгмийн эрх зүйн тодорхойлолт байдаггүй зэргээс бүх ТББ-ууд өөрсдийгөө иргэний нийгэм гэж нэрлэх боломжтой болдог нь салбарын мэргэжлийн холбоод, олон нийтийн ашиг сонирхлыг төлөөлсөн ТББ-уудыг хооронд ялгахад, ялангуяа төрийн бодлогыг хэлэлцэх үйл ажиллагаанд зөв сонирхлын бүлгүүдийг татан оролцуулахад ихээхэн хүндрэл гардаг.

⁹ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 10-р заалт

¹⁰ Үндэсний Статистикийн Хороо, “Аж ахуйн нэгжийн бүртгэл”

Иргэний нийгэм бол эрч хүчтэй тоглогч мөн

Иргэний нийгэм нь ерөнхийдөө улс орны засаглал, цаашлаад үндэсний эдийн засгийн хамгийн чухал салбар - олборлох үйлдвэрлэлийн засаглалд чухал үүрэг гүйцэтгэсэн. 1990-ээд оны сүүл, 2000-аад оны эхэн үеэс олон нийтийн анхаарал, түүнийг дагаад иргэний нийгмийн анхаарал уул уурхайд хандаж эхэлсэн нь эхэндээ байгаль орчин, орон нутгийн асуудалд чиглэгдэж байсан бол яваандаа салбарын ил тод байдал, татвар тэгш шударга байх зарчим, гэрээ хэлэлцэл, баялгийн шударга хуваарилалт зэрэг олон чухал асуудлуудыг хөндөх болжээ. Салбарт тодорхой шинэчлэлүүд гарч, уул уурхайн бодлогын хэлэлцүүлэгт олон нийт оролцдог, салбарын бодлогыг сайжруулах, хэрэгжүүлэхтэй холбоотой төрийн хариуцлага нэмэгдсэн нь ерөнхийдөө иргэний нийгмийн оролцооны үр дүн байлаа. Тэдгээрийн зарим жишээг доор дурдав.

- Өөрчлөлт шинэчлэлийг түүчээлсэн нь

Зарим бодлогын асуудалд анхаарал хандуулахад иргэний нийгмийн байгууллагууд чухал үүрэг гүйцэтгэсэн. Жишээ нь, уул уурхайгаас үүдэн байгаль орчинд эвдрэл гарч эхэлсэн 1990-ээд оны сүүл, 2000-аад оны эхэнд иргэд байгаль хамгаалах бүлгүүд байгуулж, салбарын зүгээс өөрчлөлт хийх, уул уурхайн үйл ажиллагаанд тавих байгаль орчны стандартыг чангатгахыг шаардаж эхэлсэн. Гол мөрнөө хамгаалах нутгийн иргэдийн хөдөлгөөнүүд олширч, нэрд гарахын хирээр тэд албан, албан бус сувгуудаар мэдээлэл солилцох, харилцан суралцах ажлыг хийж эхэлсэн нь 'гол мөрний хөдөлгөөнүүдийн' сүлжээг үүсгэв. Гол мөрний 12 хөдөлгөөнийг нэгтгэсэн Монголын Байгаль Хамгаалах Иргэний Хөдөлгөөний Эвсэл (МБХИХЭ) 2006 онд байгуулагдав. 2008 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байгаль орчны хөдөлгөөнүүд, ТББ-уудыг нэгтгэсэн Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөл байгуулагдав. Өдгөө, эдгээр нь нийт 700 орчим гишүүн байгууллагууд байдгаас 160-аад нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг.¹¹ Нэгэн үе, Байгаль орчны яамтай үр дүнтэй хамтарч ажиллан, байгаль хамгаалах бодлогыг боловсруулалцаж, байгаль хамгаалах төслүүдийг төрөөс санхүүжүүлэх шийдвэр гаргалцаж явсан үг зөвлөлийн туйлын зорилго нь уул уурхай байгаагүй ч, уул уурхайн бүс нутагт байгаль орчныг хамгаалах чиглэлээр ажилладаг олон ТББ-ууд уг зөвлөлийн гишүүн байсан юм. Энэ зөвлөл, түүний гишүүдийн үйл хэрэг байгаль орчны стандартыг сайжруулах, уул уурхайн компаниудын байгаль орчны төлөвлөгөөнд тавих хяналтыг чангатгахад тусалсан юм. Энэ үед үүсэн гарсан иргэний нийгмийн олон санаачилгууд, тухайлбал Хоёр Толгой Зөвлөл Оюу Толгойн зэс, Таван толгойн нүүрсний төслүүдэд хөрөнгө оруулагчидтай хийж байсан засгийн газрын хэлэлцээр, оролцогч талуудтай хамтран, уул уурхайн маргааныг хянан шийдвэрлэх механизм бий болгоход анхаарал тавин ажиллаж байсныг дурдах хэрэгтэй. МБХИХЭ 2008 онд задарч, орыг нь Гол Нууруудын Нэгдсэн Хөдөлгөөн (2009) залган авсан. Түүний үйлдлийг зарим оролцогч талууд хэт даварсан гэж үзэж байсан ч чухам түүний ачаар голын ай сав, ой бүхий газарт уул уурхайг хориглосон урт нэртэй хууль батлагдсан юм.¹² Улс орны нутаг дэвсгэрийн ихэнх хэсэгт уул уурхайг хориглосон уг хуулийн хэрэгжилт жигд байсангүй. Грийн Нобел, Байгаль орчны Голдман шагнал (2007) хүртсэн Онги гол хөдөлгөөний тэргүүн Ц. Мөнхбаяртай нэгдсэн хөдөлгөөний хэсэг гишүүд хууль жигд хэрэгжүүлэхийг шаардаж 2011 онд засгийн газрын ордны гадаа жагсаал зохион байгуулж, буу гаргасан хэрэгт баривчлагдан, 2013 онд олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулсан хэргээр хорих ялаар шийтгэгджээ. Гэсэн ч, уул уурхайд сөрөг нөлөөлөлд өртсөн орон

¹¹ Монголын Байгаль Орчны Иргэний Зөвлөл, "МБОИЗ-ийн тухай."

¹² Улсын Их Хурал, "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль."

нутгийн иргэдийн дундаас анх үүссэн иргэний хөдөлгөөнүүд салбарын шинэчлэлд том үүрэг гүйцэтгэж чадахаа нотлон харуулжээ.

Шилэн дансны тухай хууль бол иргэний нийгмийн түүчээлсэн дорвитой шинэчлэлийн нэг жишээ юм. Уг хуулиар төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрүүд үйл ажиллагаа, санхүүгийн мэдээлээ дэлгэрэнгүй тайлагнах үүрэг хүлээнэ. Нээлттэй нийгэм форумын дэмжлэгээр “Шинэ захиргааны санаачилга” ТББ-аас дүүргийн төрийн байгууллагуудын төсвийг ил тод болгох зорилгоор “Шилэн хэтэвч” түршилт төслийг (2006) хэрэгжүүлсний дараа уг хуулийг баталжээ.¹³ Өнөөдөр, төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэрүүдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, санхүүгийн тайлан, төсвийн төлөвлөгөөнөөс гадна 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий мөнгөн гүйлгээний мэдээллийг шилэн данснаас харж болно.¹⁴ Уг хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой саад бэрхшээл, мэдээллийн чанар, хэлбэрийг сайжруулах шаардлага байгаа ч, шилэн данс нь засгийн газраас хариуцлага шаардахад ашиглаж болох мэдээллийн хүчирхэг эх үүсвэр болж хэдийнээ чаджээ.

- Ач холбогдол бүхий яриа хэлцэлд оролцсон нь

Бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, төр болон компаниудтай хамтран ажиллах нь уул уурхайн салбарт шинэчлэлийг эхлүүлэх иргэний нийгмийн үйл ажиллагааны үндсэн арга барил билээ. 2006 онд Азийн Сангийн дэмжлэгээр байгуулагдсан Хариуцлагатай Уул Уурхайн Санаачилга (ХУУС), мөн онд Монгол Улс нэгдэн орсон “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга” (ОУИТБС) нь олон оролцогч талуудын санаачилгаар үүсэж, өөр өөр үр дүнд хүрсэн ИНБ-уудын жишээ юм. 2008 онд иргэний нийгмийн гол төлөөлөл болох МБХИХЭ задарснаар ХУУС анх байгуулагдсан эрч хүчээ алдаж, ХУУС-ын үйл ажил хэсэг хугацаанд өөр өөр хэлбэрээр үргэлжилсэн ч оролцогч талуудаас анх үзүүлж байсан шиг дэмжлэгийг ахин хэзээ ч авч чадаагүй юм.¹⁵ Хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг ХУУС дэмжин, уул уурхайн тодорхой төслүүдийг үнэлэхэд уг зарчмуудыг ашиглах журмыг боловсруулжээ. Өдгөө, эрдэс баялгийн салбарын гол дуу хоолой болсон Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци хариуцлагатай уул уурхайн санаачилгын зарчмуудыг удирдан салбарын компаниудыг хариуцлагатай уул уурхайн хөтөлбөрт нэгтгэх ажлыг зохион байгуулж байна. Гэвч бусад оролцогч талуудын төлөөлөл бараг байхгүй байна.

2006 оноос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ОУИТБС бол талуудын оролцооны чухал талбар бөгөөд салбар дах ил тод байдлын стандартыг тэргүүлдэг. Уул уурхайн компаниудын төлсөн болон засгийн газрын хүлээн авсан татвар төлбөр, тусгай зөвшөөрөл, гэрээ, бенефициар өмчлөгчид, үйлдвэрлэл болон салбарын үйл ажиллагааны талаар ойлголт авахуйц чухал мэдээлэл, компани болон төрийн аль алианаас нь хариуцлага нэхэхэд шаардагдах бусад бүх дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан тайланг ОУИТБС жил бүр гаргадаг. Уг санаачилгын үйл хэрэг, тайлангийн агуулгыг сайжруулах, ил тод байдлын фронтод шинэчлэлийг улам гүнзгийрүүлэхэд иргэний нийгмийн оролцоо голлох үүрэг гүйцэтгэдэг. Жишээ нь, ОУИТБС-ын хүрээнд тайлагнадаг мэдээллүүдийн олонх нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд тайлагнахаар заагдсан мэдээллүүд байдаг. ОУИТБС-с анх дэвшүүлсэн, бенефициар эзэмшигч, гэрээний мэдээллийг тайлагнах явдал өдгөө уул уурхайн төсөл, компаниудын ил тод байдлын нэг стандарт болжээ. Уул

¹³ Ч.Сосормаа, “Иргэд нь төсвөө мэддэг болсон цөөхөн улсын нэг нь Монгол.”

¹⁴ ББЗХ, “Монголын төрийн өмчит уул уурхайн үйлдвэрүүд: Шилэн дансны мэдээллийг гүнзгий судлах нь.”

¹⁵ Байгаль орчны шударга ёсны дэлхийн атлас, ““Урт нэртэй хууль”-ийг тойрсон уул уурхайн эсрэг жагсаал, маргаан, Монгол Улс.”

уурхайн салбар дах авлигын эрсдэлтэй хэрхэн тэмцэх талаар хэлэлцүүлэг явуулдаг талбарын үүргийг ОУИТБС үр дүнтэй хэрэгжүүлж ирсэн ба төр болон компанийн оролцогч талуудтай салбарын засаглалыг сайжруулах бодлогын яриа хэлцэл хийхэд иргэний нийгмийг оролцоог хангах онцгой боломжийг олгодог.

Гэвч, ХУУС, ОУИТБС-ыг бүрэн ашиглахгүй байна гэх шүүмжлэл гардаг. Тухайлбал, ОУИТБС-ын шийдвэр гаргагч этгээдүүд болох олон талт оролцогчдын бүлгүүд нь салбарын гурван гол тоглогчийг эгнээндээ багтаасан ч бодлогын бусад чухал яриа хэлцэл өрнүүлдэггүй; төрийг төлөөлсөн дээд тушаалын албан хаагчид үүргээ доод тушаалын албан хаагчдад шилжүүлдгээс бүлэг дэх төрийн дээд түвшний дэмжлэг байхгүй болсон¹⁶ зэргийг дурдаж болно. Эл үйлдлүүд нь ОУИТБС-ыг бий болгох, хөгжүүлэхэд Төлсөн авснаа нийтэл (ТАН) тэргүүтэй иргэний нийгмийн гүйцэтгэсэн үүрэгтэй тэс зөрүүтэй үйлдэл юм. Чадавх, эх үүсвэр хязгаарлагдмал байдлаа үл хайрхан ТАН, түүний гишүүд ОУИТБС-ын үйл хэрэгт идэвхтэй оролцож, шинэчлэлийн санал санаачилгуудыг тэргүүлсээр ирсэн ба, ОУИТБС-ын баталгаажуулах тайлангийн дүгнэлтэд ‘ОУИТБС-ын үйл хэрэгт бүрэн дүүрэн, идэвхтэй, үр дүнтэй оролцох зорилтоо иргэний нийгэм бүрэн биелүүлсэн гэж үүлзаж ярилцсан дийлэнх оролцогч талууд үзсэн байна’ гэж дурджээ.¹⁷

ИНБ-үүд өнгөрсөн 20 жилд уул уурхайн бүс нутагт тоймгүй олон чадавхжуулах ажил, олон нийтийн хэлэлцүүлэг хийсэн. Өмнөговь, Дорноговь зэрэг уул уурхай хөгжсөн аймгууд уул уурхайн асуудалд иргэний нийгэм, идэвхтэй иргэдийг оролцуулан олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлсэн. Эдгээр олон нийтийн хэлэлцүүлгийг ОУИТБС болон бусад нийслэлд төвтэй байгууллагууд хамтран зохион байгуулж ирсэн ч сүүлийн үед орон нутгийн удирдлагууд бие даан зохион байгуулах нь олширсон нь тэдгээрийг уул уурхайгаас нутгийн иргэдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэх боломж харсантай холбоотой.

Монгол Улс Нээлттэй Засгийн Түншлэлийн (НЗТ) гишүүн. НЗТ-ийн хүрээнд иргэний нийгэм, төр засаг хамтран улс орны засаглалыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө гаргадаг. Хэдий үйл ажиллагааны төлөвлөгөөний олонх нь ажил хэрэг болдоггүй ч, засгийн газартай шууд хамтран ажиллах, шинэчлэлийг гүнзгийрүүлэх ийм боломж ИНБ-уудад тэр бүр олдоод байдаггүй гэдэг үтгаараа маш чухал юм.

- Засгийн газрын хариуцлагыг нэмэгдүүлсэн нь

Олборлох салбарын бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд төрийн хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэхэд иргэний нийгэм ямагт хүчин чармайлт гаргасаар ирэв. Иргэний нийгмийн шаардлагын үрээр тусгай зөвшөөрөл олгох ажиллагаа ил тод, хатуу хяналттай болов. Орон нутгийн хөгжилд оруулах уул уурхайн хувь нэмрийг тодорхойлсон орон нутгийг хөгжүүлэх хамтын ажиллагааны гэрээг орон даяар ашигладаг болсон нь орон нутгийн иргэний хөдөлгөөнүүдийн гавьяа байлаа. Төрийн өмчит компани, төрийн байгууллагын худалдан авалтад иргэний нийгмийн бие даасан шинжээчид оролцох болсноор худалдан авах үйл ажиллагаа сайжирч ил тод байдал нь нэмэгдэв. Төрийн өмчит уул уурхайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүдийг оруулж, иргэний нийгмийн оролцоотой бие даасан хяналтын этгээдийг төрийн байгууллагын дэргэд байгуулах явдал улам дэлгэрэв. Тухайлбал, 2023 онд Эрдэнэс Монгол зэрэг төрийн өмчит гол үйлдвэрийн газрууд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээ нээлттэй сонгон

¹⁶ Жишээ нь, ОУИТБС, “ОУИТБС-ын Монгол дах баталгаажуулалтын тайлан.”

¹⁷ ОУИТБС.

шалгаруулсан; Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлд голдуу иргэний нийгмийн төлөөллийг оруулж, төрийн байгууллагын түвшинд авлигатай тэмцэх арга хэмжээг чангатгах ажилд оролцуулсан зэргийг дурдаж болно. Хамгийн сүүлд, олон төрлийн мэдээллийг олон нийтэд нээлтэй болгосноор иргэний нийгмийн бүлгүүд тэдгээрийг бодлогын хэлэлцүүлэг, хяналт тавих зорилгод ашиглаж эхлээд байна. Монголын дата клуб, Тунгаахуй зэрэг бүлгүүд албан ёсны эх үүсвэрээс авсан уул уурхайн салбарын сонирхолтой мэдээллийг олон нийтэд хүргэж, бодлогын хэлэлцүүлгийн чанарыг сайжруулж байна. Төрийн хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд иргэний нийгэм оролцож буйн жишээнээс цөөнийг дурдвал ийм байна.

Дээрх ажлуудын нэлээд нь олон улсын санаачилга, гадаадын санхүүжилтээр хэрэгжсэнийг дурдах нь зүйтэй. Сайн засаглал, ил тод, хариуцлагатай байдал, авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн иргэний нийгмийн дийлэнх санаачилгууд чухам эдгээр эх үүсвэрүүдээс санхүүжсэн байдаг.

Иргэний нийгэмд тулгарч буй сорилтууд

Иргэний нийгмийн оролцооны үр дүнд олборлох салбарын бодлогод гарсан дээрх амжилтуудын зэрэгцээ, иргэний нийгмийн үр дүнтэй байдалд сөргөөр нөлөөлөгч олон хүчин зүйлс байна. Тэдгээр сорилтуудын ихэнхийг иргэний нийгмийн үйл хэргийг төрөөс дэмжих замаар шийдвэрлэж болох бол, зарим нь иргэний нийгмийг хааж хорих гэсэн нийтлэг хандлагаас үүдэлтэй байх ба үүнийг зөв шийдвэрлэхгүй бол гүн гүнзгий үр уршиг дагуулж болзошгүй.

Иргэний нийгэмд хандсан үйл ажиллагаа явуулдаг үндэсний болон олон улсын байгууллагууд Монгол дах иргэний нийгмийн орчин “дарамттай” байгааг анхааруулжээ. Иргэний нийгмийн төлөв байдлыг дэлхийн хэмжээнд үнэлдэг Олон Улсын CIVICUS байгууллага Монгол Улсын иргэний нийгмийн орон зайг “хавчигдмал” гэж үнэлжээ.¹⁸ “ИНБ-ууд ОУИТБС-ын үйл хэрэгт идэвхтэй оролцсон хэвээр байгаа ч төрийн бодлого боловсруулалтад оролцоход нь зарим саад тотгор учирч байгаа нь төр засагтай зарим талаар холбоотой буюу олборлох салбарт эрх зүйн шинэчлэл хийх, салбарын бодлого боловсруулахад олон нийттэй зөвшилцөх хуулийн заалтаас ухарсантай холбоотой” гэж Монголд хийсэн ОУИТБС-ын баталгаажуулалтын сүүлчийн дүгнэлтэд (2022) дурджээ. ОУИТБС-ын удирдах зөвлөл цааш дүгнэхдээ “хууль тогтоох засаглалын шинэчлэлээр дамжуулан байгалийн баялгийн засаглалын асуудлаар иргэний нийгмийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлаж магадгүй гэж санаа зовж байна” гэжээ.¹⁹ ТББ-ын тухай хатуу хуулийн төсөл парламентаар хэлэлцэгдэж байгаа нь ИНБ-уудад эрсдэл үүсгэхийг Олон улсын Бүгд Найрамдахчуудын Хүрээлэн анхааруулж байна.²⁰

Ковид-19 цар тахлын үеэр олон оронд авсан жагсаал цуглаан хийх, эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хаагдуулсан хязгаарлалтын арга хэмжээ Монгол Улсыг ч тойрсонгүй. Мэдээж зарим арга хэмжээ хүний амийг аврах, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалахад тус болсон ч, зарим арга хэмжээний үр дагавар цар тахал дууссанаас хойш ч үргэлжилсээр байна. Тухайлбал,

¹⁸ CIVICUS, “Иргэний нийгмийн төлөв байдал”

¹⁹ ОУИТБС-ын Удирдах зөвлөл, “Монгол Улс 2019 оны ОУИТБС-ын стандартыг хэрэгжүүлэхдээ дунд зэргийн нийлбэр оноо авсан.”

²⁰ Б.Женсен, “Иргэний нийгмийн ардчилалд оруулж буй хувь нэмрийг үл харгалзан Монголын төрийн бүс байгууллагууд эрсдэлд ороод байна.”

ковидоор өвчилсөн шүгэл үлээгчийг хожим нь худал мэдээлэл тараасан хэргээр баривчилсан нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн жишээ юм.

Улс орны эдийн засаг, уул уурхай, дэд бүтцийн том төслүүдийг урагшлуулахад иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийн талаарх төрийн өндөр албан тушаалтан, уул уурхайн компаниудын байр суурь уул уурхайн засаглалаар ажилладаг иргэний нийгэмд тулгардаг магадгүй хамгийн том эрсдэл юм.

Монгол Улсын стратегийн салбарын бүтээн байгуулалтыг санаатайгаар тасалдуулж, хорлон сүйтгэх үйл ажиллагаа явуулсан үйлдлүүдийг хууль хяналтын байгууллагаар шалгуулах, алдагдсан боломжийн өртгийг нэхэмжлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 2022 онд байгуулсан.²¹ Эл бүрхэг заалтыг ямар ч байдлаар ойлгож болох бөгөөд хууль сахиулах байгууллагын мөрдлөгөөс айн, иргэдийн санааг зүй ёсоор зовоосон эдийн засаг, нийгэм, байгаль орчин, засаглалын асуудлаар иргэний нийгэм арга хэмжээ авах боломжгүй нөхцөл үүсэж болзошгүй. Сүхбаатар аймагт өрөмдлөг хийж байсан компанийн ажлыг үндсэрхэг үзэлтэй нэгэн ТББ зогсоосон нь хилийн цаана газрын тос олборлодог Хятад компанийн санхүүжилтээр хийгдсэн ажил байсныг тагнуулын мэдээ баталсан тухай тухайн үеийн Хууль зүйн сайд Нямбаатарын хэлсэн үгнээс дээрх санааг харж болно.²² Мөн ярилцлагадаа, Оюу Толгойн Хяналт ТББ-ын идэвхтэн Дүгэрсүрэнгийн Сүхгэрэлийг Эгийн голын төслийг зогсоосон улс төрийн кампанит ажлыг удирдсан гэж буруутган, ихэнх нь өөрийнх нь удирдлагад байдаг хууль сахиулах байгууллагуудад түүнийг мөрдөн шалгахыг шаарджээ. Тун удалгүй Сүхгэрэлд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэжээ. Түүнээс гадна, Их Бага Баяншарга ТББ-ын иргэний нийгмийн зүтгэлтэн Л.Борыг ураны хайгуул, олборлолт хийдэг компаниудыг шүүхэд өгсөн хэргээр мөрдөн шалгасан. Мөрдөн шалгалт хийх үндэслэл байсан байж болох ч, дээрх үйлдлүүдийг том төслүүдийн буруу менежментийг шүүмжилсэн иргэний нийгмийн амыг барих гэсэн оролдлого гэж үзэж бас болно. ИНБ-ын үүрэг рольд эргэлзсэн өөр нэг төрийн өндөр тушаалтан, одоогийн Хууль зүйн сайд Б. Энхбаяр (2019 онд Хууль зүйн дэд сайд) “ТББ нэрийн доор үндэсний аюулгүй байдалд заналхийлж, үндэстнийг хагалан бутаргах далд зорилготой хэлбэр цагаандаа гарч эхэллээ” гэж нэгэнтээ хэлсэн байдаг.²³

Энэ бүхнээс харахад, төр засгаас иргэний нийгмийн орон зайг хумих томоохон оролдлого хийж байна гэж үзэж болохоор байна. Эл дүр зураг дэлхийн хэмжээнд ч ажиглагдаж байгааг CIVICUS-ын судалгаанд “байгалийн баялаг ихтэй олон улсад иргэний нийгмийн орон зай сүүлийн жилүүдэд хумигдсан” гэснээс харж болно. Хүний эрх хамгаалагчдын асуудал эрхэлсэн НҮБ-ын тусгай илтгэгч “байгаль орчин, нийгмийн эрсдэлийн талаар үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдэлснийх нь төлөө Дэмбэрэлсүрэнгийн Сүхгэрэлийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэсэнд санаа зовж...” буйгаа илэрхийлжээ.²⁴

Хэдийгээр баримтаар нотолсон нь нэг ч байхгүй ч, иргэний нийгмийн хөдөлгөөн, өөрсдийн эрхийг хамгаалсан нутгийн иргэдийг “бусдыг дарамталж мөнгө салгагч” гэж нэрлэх явдал ТББ-уудын зүгээс хүртэл гарах боллоо. ТББ-уудыг уул уурхайн компанийг дарамтлан мөнгө нэхсэн хэрэгт сэжиглэсэн, мөрдөн шалгасан хэд хэдэн тохиолдол гарсан нь үнэнтэй ч, уг явдлыг иргэний нийгэм бүхэлдээ мөнгө дарамталдаг мэтээр хавтгайруулан нялзаах нь иргэний нийгмийн үйл ажиллагаанд хууль

²¹ Монгол Улсын Засгийн газар, “Засгийн газрын хуралдааны тойм”

²² Өнөөдөр сонин, “Х. Нямбаатарын ярилцлага.”

²³ УБ Инфо “Цагаандаа гарсан шантаажчид буюу ТББ-уудын үнэн төрх”

²⁴ НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагчдын асуудал эрхэлсэн тусгай илтгэгч, “Монгол Улс: Дүгэрсүрэнгийн Сүхгэрэлийн эсрэг эрүүгийн мөрдөн байцаалтын байдал.”

тогтоомжийн хүрээнд хязгаарлалт тавих, үйл ажиллагаанд нь хүндрэл үүсгэх нэмэлт эрсдэлийг бий болгоно.

1.1.3. Уул уурхай дах иргэний нийгмийн орон зайн талаарх буруу ойлголт

Уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн оролцоо нь өөрөө их нарийн төвөгтэй асуудал тул, уг засаглалд оролцогч талуудын үүрэг роль, иргэний нийгмийн тоглогчдод тулгардаг эрсдэлүүдийг бүрэн ойлгож мэдэх нь юу юунаас чухал. Уул уурхайтай холбоотой зөрчилдөөнийг шийдвэрлэхэд төр засаг үр нөлөө муутай нь харагдсан. Монгол Улс авлигын эрсдэл, авлигын төсөөллийн индексээр өндөрт ордог, уул уурхайн салбар дахь хээл хахууль, албан тушаалаа урвуулан ашиглах тохиолдол элбэг гардаг орон. Ийм нөхцөлд салбарын бодлого, үйл ажиллагааг өөрчлөхөд чухал үүрэг гүйцэтгэх чадвартай иргэний нийгэмтэй байна гэдэг нь нийгэмд асар их ач холбогдолтой. Иймд, иргэний нийгэм оршин тогтнох эрүүл, хүчирхэг орон зайтай байх нь ялангуяа баялаг ихтэй орнуудын хувьд нэн чухал асуудал юм.

Уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайг үнэлэх судалгаа Монголд сүүлийн жилүүдэд огт хийгдээгүй. Иргэний нийгмийн орон зайг ажиглаж, судалсан ажлын дийлэнх нь олон улсын судалгаа, шинжилгээний хүрээнд хийгдсэн (тэдгээрийн зарим үр дүнг өмнөх бүлгүүдэд дурдсан), тухайлан улс орны хэмжээнд хийсэн цөөн хэд нь уул уурхайн засаглал дах оролцоо гэхээсээ иргэний нийгмийн орчныг өргөн хүрээнд авч үзсэн, эсвэл иргэний нийгмийн орон зайг бүхэлд нь бус, зөвхөн түүний тодорхой нэг хэсгийг нь тусгайлан авч үзсэн судалгаанууд байлаа.

ДеФакто хүрээлэн 2020 онд онцолсноор “төрийн бодлого, хууль тогтоох үйл ажиллагаа дах ТББ-ын нөлөөлөл харьцангуй сул”, мөн төрөөс олгох санхүүжилт буурсан энэ үед иргэний нийгэм “ТББ-ын санхүүжилтийг хязгаарлах хууль батлагдах” эрсдэлтэй нүүр тулсан.²⁵ Азийн Хөгжлийн Банк, иргэний нийгмийн хамтын ажиллагааны 2019 оны тайланд “ИНБ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл муу байгаа нь төр засгийн зүгээс ИНБ-тай харилцаа тогтоох, тэдгээрийн санаачилгыг дэмжих боломжуудыг хязгаарлаж, иргэний нийгмийн хөгжлийг саатуулж байна”, мөн “дотоод, гадаад эх сурвалжаас санхүүжилт босгох туршлага муутай байгаа нь ИНБ-уудад тулгарч буй хамгийн том сорилтуудын нэг юм” гэж цохон тэмдэглэжээ. Иргэний нийгмийн чиглэлээр өмнө хийсэн нэг судалгаанд, олон жил иргэний нийгмийн төлөө зүтгэж байгаа Т. Ундаръяа “улс төр, эдийн засаг, соёл, санхүүгийн таагүй орчинд ИНБ-ууд төр засаг, олон улсын байгууллагын дэмжлэггүйгээр оршин тогтносоор ирсэн” гэж тэмдэглээд, “уул уурхайн огцом өсөлтөөс үүдэлтэй эрсдэл, боломж сүлэлдсэн шинэ 10 жилийн босгон дээр, иргэний нийгмийн салбар авлига, хүний эрхийг зөрчих явдалтай тэмцэхэд нь иргэд, нутгийн иргэдийг дэмжих, төр, хувийн хэвшлийн хариуцлагыг нэмэгдүүлэх, илүү тэгш байдлыг хангасан хөгжлийн замыг тодорхойлох амин чухал үүргээ гүйцэтгэх чадвар дутмаг” байгааг сануулжээ.²⁶ Иргэний нийгмийн орон зайг судлах явцдаа “ИНБ-уудад үзүүлдэг төрийн дэмжлэг, ИНБ-ын төсвийн орчин, иргэдийн санаа бодлыг хүлээн зөвшөөрөх төрийн хүсэл сонирхол сул” байгаагаас “ИНБ-уудын санхүүгийн чадавх сайжраагүй, орлогын өөрчлөлтөд эмзэг, мэдрэг” байгааг 2021 онд Иргэний Нийгмийн Консорциум тухайн судалгаагаар баталсан.²⁷

²⁵ Алтанхуягийн Бат-Оргил, Ганхуягийн Батхишиг, “Төрийн бус байгууллагуудын институтын орчны харьцуулсан шинжилгээ.”

²⁶ Т. Ундаръяа, “Монгол Улсын иргэний нийгмийн хөгжлийн байдал.”

²⁷ Ц.Батсугар, О. Саранчулуун, ЭйАйСиЭй, “Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа.”

Дээрх судалгаанууд, ИНБ-уудад тулгардаг гол сорилтуудын талаар мэдээлэл цуглуулснаас бус сайн засаглалыг бий болгох, иргэдийн хүртэх байгалийн баялгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд иргэний нийгэм ямар хувь нэмэр оруулсан талаар тодорхой зүйл дурдаагүй. Иймд, дээрх чиглэлээр ажилладаг ИНБ-уудыг онцгойлон судалж, уг орхигдлыг нөхөх нь манай судалгааны гол зорилго байв. Байгалийн баялаг ихтэй орнуудад иргэний нийгмийн оролцогч талуудтай шууд хамтран ажилласан олон жилийн туршлагатай ББЗХ-ийн өөрчлөлтийн онол буюу нөлөөллийг бий болгох иргэний нийгмийн оролцооны хүрээг энэ судалгаанд жишиг болгон ашигласан нь маш үр дүнтэй байлаа. Мэдээллээр хангагдсан, хүчирхэг иргэний нийгэм бол байгалийн баялгийн засаглалд хувьсал дэвшил, тогтвортой өөрчлөлт авчрах үндсэн хэрэгсэл гэдэгт ББЗХ итгэдэг. Иргэний нийгэм нь хариуцлага сахиулагчийн үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж чаддагаас гадна, байгалийн баялгийн сайн засаглалын үндэсний, олон улсын хэм хэмжээг тогтооход онцгой үүрэг гүйцэтгэнэ. Түүнчлэн, сайн засаглалын үр ашгийг таниулан ойлгуулах, сайн засаглалыг төлөвшүүлэх зардлыг бууруулах, аргачлалыг боловсруулах, сайн засаглалыг хэрэгжүүлэх механизм, харилцан зөвшилцлийг бий болгох, өөрчлөлт шинэчлэл хийх улс төрийн хүсэл эрмэлзлэлийг төрүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Иргэний нийгэм нь, хариуцлага сахиулагчийн үүргийнхээ хүрээнд, компани, төр засгийн үйл ажиллагаанд хүчтэй хяналт тавих, тэднээс хариуцлага шаардсан олон нийтийн хөдөлгөөнийг үүсгэн бий болгох, тэдгээр хөдөлгөөнийг оновчтой уялдуулах замаар өөрсдийн зорилго зорилтыг хэрэгжүүлэх, илүү оновчтой стратегийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлнэ.²⁸ Эл үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь төр засаг, бусад оролцогч талуудын дэмжлэг, хүчин чармайлт, чадавхжуулах тогтмол үйл ажиллагаа, үр ашигтай түншлэл, мэдээ, мэдээллийн илүү нээлттэй байдал, үйл ажиллагаа явуулах санхүүжилт маш чухал байдаг.

1.2. Судалгааны зорилго, зорилт, аргачлал

Энэ судалгааны зорилго нь Монгол Улсын уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайг ойлгох, үнэлэх, уул уурхайн бодлого, тэдгээрийн хэрэгжилтэд иргэний оролцоог үр дүнтэй байдлаар хангах боломж, тулгарах бэрхшээлүүдийг олж тогтооход оршино.

Уг зорилгыг хэрэгжүүлэхийн тулд иргэний нийгэм, уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайг бүрдүүлэгч оролцогч талуудын үүрэг ролийг ойлгох, иргэний нийгмийн оролцооны хөдөлгөгч хүчийг судлах, иргэний нийгэмд тулгардаг сорилтуудыг олж тогтоох, ИНБ-уудын гүйцэтгэх үүрэг роль, түншлэлийн талаарх төр засаг, компанийн байр суурь, уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайг сайжруулах боломжуудыг судаллаа.

Холбогдох мэдээлэл, оролцогч талуудын судалгаа хийх, иргэний нийгмийн гол төлөөлөгчидтэй фокус бүлгийн уулзалт зохион байгуулах, иргэний нийгэм, төр засаг, салбарын төлөөлөлтэй биечлэн уулзах аргуудыг энэ судалгаанд ашиглалаа. Түүнээс гадна, Монгол болон бусад улсад ИНБ-уудтай ажилласан арвин туршлагатай ББЗХ, АМЭП судалгааны ажилд гүн дэмжлэг үзүүлсэн болно.

- **Холбогдох мэдээллийн судалгаа**

Уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайн талаарх хэвлэлийн нийтлэл, тайлан, тохиолдлын судалгааны материалуудыг ул суурьтай судаллаа. Уг судалгаанд, дотоодын болон олон улсын байгууллагуудын зүгээс иргэний нийгмийн орон зайн талаар хийсэн дүн шинжилгээ, иргэний нийгмийн салбарын албан ёсны статистикийг ашиглав. Түүнчлэн, иргэний нийгмийн эрх

²⁸ ББЗХ, “Иргэний нийгмийн үнэлгээ.”

зүйн орчныг судалсан болно. Судалгаанд ашигласан материалуудын жагсаалтыг энэ тайлангийн хавсралтаас үзнэ үү.

- **Иргэний нийгмийн байгууллагуудын асуумж судалгаа**

Өөрийн болон бусад ИНБ-уудын гүйцэтгэдэг гол үүрэг, Монгол Улсын уул уурхайн салбарын засаглалд оролцох боломж, тулгардаг бэрхшээлийн талаарх түүвэрт хамрагдсан иргэний нийгмийн байгууллагуудын мэдлэг, мэдээллийг асуумж ашиглан цогц байдлаар үнэллээ. Асуумжийг ИНБ-уудын үйл ажиллагаа, хөтөлбөрийн талаар мэдээлэл цуглуулахад чиглүүлсэн.

ББЗХ нь судалгаа авах зорилгоор иргэний нийгмийн олон бүлгүүдэд шууд болон тэднийг эгнээндээ нэгтгэсэн сүлжээ, эвслээр дамжуулан хандсан. Нийт 105 байгууллага, эвсэлд асуумжийн судалгаанд оролцох хүсэлт тавьсан. Судалгааны хамгийн том зорилтот бүлэг нь олборлох салбарын засаглалын талбарт олон асуудлаар идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудын гол сүлжээ бөгөөд, өргөн хүрээний оролцогч талуудад суурилсан Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) иргэний нийгмийн гол хамтрагч ТАН Монгол эвсэл байлаа. Мөн, хүний эрх, байгаль орчин, жендэр, төсвийн асуудал болон бусад асуудлаар ажилладаг байгууллагуудыг судалгаанд хамруулахад ихээхэн хүчил чармайлт тавьсан. Асуумжийг цахимаар бөглөх боломжгүй тохиолдолд цаасаар бөглөх боломжийг олгосон. Нийт 47 байгууллага судалгаанд оролцсон. Цаасан асуумжаар биечлэн судалгаа авах ажлыг хоёр туслах судлаач гүйцэтгэсэн. Судалгааг 2023 оны 10-р сараас дундаас эхэлж гурван долоо хоногт дуусгасан.

Асуумжийг, ББЗХ-ийн Байгалийн Баялгийн Түнхгийн шийдвэрийн хэлхээний хүрээг Зураг 1) ашиглан, Монгол болон дэлхийн хэмжээнд иргэний нийгэмтэй ажилласан туршлагад тулгуурлан боловсруулав. Эрдэс баялгаа ашиглан тогтвортой хөгжлийг бий болгоход нь улс орныг удирдан чиглүүлэх шийдвэрийн хэлхээний гол үе шатуудыг уг хүрээгээр тодорхойлсон байдаг. Асуумжийг боловсруулахад ББЗХ-ийн Монгол дах баг, мөн Засаглалын багийн гишүүдтэй хамтран оролцсон. Иргэний нийгмийн оролцооны боломжит чиглэлүүдийг шийдвэрийн хэлхээний хүрээн дэх бодлогын асуудал тус бүрээр гаргах, ИНБ-уудын хамгийн идэвхтэй ашигладаг оролцооны чиглэлүүд, тэдгээрийн хэлбэр, хэв шинжийг олж тогтоох асуултуудыг боловсруулах ажлыг төслийн баг хийж гүйцэтгэсэн. Асуумжийн төслийг дотоодын иргэний нийгмийн мэргэжилтнүүд, АМЭП-ын багаар хэлэлцүүлэн гарсан зөвлөмжүүдийг тусгасан.

Асуумж нь ИНБ-ын үндсэн мэдээлэл, олборлох салбарын засаглалд гүйцэтгэх ёстой болон гүйцэтгэдэг үүрэг, иргэний нийгмийг төлөөлдөг гол тоглогчид, тэдгээрт тулгардаг бэрхшээл, боломжууд гэсэн 5 бүлэгт хуваагдсан нийт 52 асуулттай. Асуултуудыг төрлөөр ангилан



Хүснэгт 1-д үзүүлэв. Асуумжийг бүрэн эхээр энэ тайлангийн Хавсралт-с үзэж болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 1. Асуумжийн нийт асуултын тоо, бүлгээр, төрлөөр

Асуултын төрөл		Асуултын тоо
Боломж		
	эрэмбэлсэн сонголттой хариулт	3
Асуултын тоо	—	3
Гол төлөөлөл		
	олон сонголттой хариулт	4
	эрэмбэлсэн сонголттой хариулт	3
	нэг сонголттой хариулт	1
	нээлттэй хариулт	1
Асуултын тоо	—	9
Гол чиг үүрэг		
	эрэмбэлсэн сонголттой хариулт	3
	олон сонголттой хариулт	1
Асуултын тоо	—	4
Ерөнхий мэдээлэл		
	нэг сонголттой хариулт	7
	олон сонголттой хариулт	4
	эрэмбэлсэн сонголттой хариулт	3
	нээлттэй хариулт	2
Асуултын тоо	—	16
Сорилтууд		
	олон сонголттой хариулт	9
	эрэмбэлсэн сонголттой хариулт	7
	нэг сонголттой хариулт	4
Асуултын тоо	—	20
Нийт	—	52

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

Уул уурхайн засаглалд оролцдог ИНБ-үүд ажиллагсдын тоо, зорилго, туршлага, эх үүсвэр, үйл ажиллагааны хэлбэрээрээ харилцан адилгүй байсан ба эдгээрийн төлөөллийг судалгаанд тэгш хамруулах зорилгоор холбогдох оролцогч талуудад хандсан. Зорилго, хамрах хүрээний хувьд хязгаарлагдмал энэ судалгааны үр дүнг ББЗХ-ийн хэрэгжүүлж байгаа бусад судалгааны дүн шинжилгээгээр баяжуулсан болно. Иймд энэ судалгааны үр дүнг Монгол Улсын иргэний нийгмийн салбарыг бүхэлд нь хамааруулан ойлгож үл болно. Гэхдээ, Монгол Улсын олборлох салбар дах иргэний нийгмийн үйл ажиллагааны дүр зургийг энэ судалгаа маш сайн гаргаж өгч чадсан ба судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллийг энд ашигласнаас өөр хэлбэрээр ашиглаж болно.

- **Иргэний нийгмийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн үүлзалт**

ББЗХ тэргүүлэгч ИНБ-үүдыг оролцуулсан фокус бүлгийн үүлзалтын 2023 оны 12-р сарын 1-ний өдөр зохион байгуулав. Үүлзалтад, холбогдох асуудлаар мэдлэг, туршлагатай, судалгааны ажилд өөрийн мэдлэг, үр чадварыг нэмэрлэх хүсэл эрмэлзэл бүхий, уул уурхайн засаглал, иргэний нийгмийн оролцоо, бодлогын судалгаа, сэтгүүл зүй, төсвийн үйл ажиллагаа, хүний эрх, жендэрийн асуудал эрхэлсэн өөр өөр түвшний иргэний нийгмийн төлөөллүүдийг урьж оролцуулсан. Фокус бүлгийн үүлзалтад, иргэний нийгмийг үнэлэхэд ББЗХ-ийн ашигладаг бусад үнэлгээний аргууд, холбогдох мэдээллийн судалгаа, иргэний нийгмийн гол байгууллагуудаас асуумжаар авсан судалгаа, гол мэдээлэл өгөгчид, төр засаг, уул уурхайн компаниудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагатай нягт холбоотой асуултуудыг ашиглав. Ялангуяа, фокус бүлгүүдийг байгуулах, зорилтуудыг тодорхойлох, хэлэлцэх асуудлыг нь боловсруулахад холбогдох мэдээллийн болон асуумжийн судалгааны үр дүнг ашигласан. Фокус бүлгийн үүлзалтын гол зорилго нь Монгол Улс дах уул уурхайн засаглал, бодлого дах иргэний нийгмийн оролцооны байдлыг туршлагатай иргэний нийгмийн төлөөлөгчид юу гэж дүгнэж байгааг мэдэх явдал байлаа.

Уулзалтад, Нээлттэй нийгэм хүрээлэнгийн уул уурхайн засаглал, стратегийн өмгөөлөл, иргэний орон зай, нийтийн боловсролоор, Ил тод байдал сан ТББ-ын сэтгүүл зүй, төсөв, уул уурхайн ил тод байдлаар, Хил хязгааргүй алхам ТББ-ын уул уурхайн ил тод байдал, орон нутгийн харилцаа, байгаль орчин, хүний эрх, жендэрийн бодлогоор, Монголын дата клубийн сэтгүүл зүй, мэдээллийн ил тод байдал, мэдээлэл ашиглалтын асуудлаар мэргэшсэн төлөөллүүд тус тус оролцлоо.

Фокус бүлгийн хэлэлцүүлгийг дараах бүлэг асуултуудаар чиглүүлсэн:

- Уул уурхайн сайн засаглалд иргэний нийгэм яагаад чухал вэ?
- ИНБ-уудын гол үйл ажиллагаа чухам ямар асуудалд чиглэгдэх ёстой вэ?
- Уул уурхайн засаглалтай холбоотой ИНБ-ын үйл ажиллагааны гол арга барил юу вэ?
- Иргэний нийгмийн байгууллагын харьцангуй сайн ажиллаж буй чиглэл юу вэ?
- Уул уурхайн засаглалтай холбоотой чухам ямар асуудлуудад иргэний нийгэм илүү чухал анхаарал хандуулах ёстой вэ?
- Төрийн байгууллага, уул уурхайн компаниуд, ИНБ-уудын хоорондын харилцаа, тэдний үйл ажиллагаа дах ИНБ-ын оролцоонд та ямар үнэлгээ өгөх вэ?
- ИНБ-уудад өнөөдөр тулгарч буй гол сорилтууд юу вэ?
- Сүүлийн таван жилийн хугацаан дах ИНБ-уудын үйл ажиллагааны орон зайг хэрхэн үнэлэх вэ?
- Уул уурхайн засаглалын асуудлуудаар ИНБ-уудын явуулж буй үйл ажиллагааны орчныг хэрхэн сайжруулж болох вэ?

Хэлэлцүүлэг өрнүүлэхэд ашигласан асуултуудын илүү дэлгэрэнгүй, бүрэн хувилбарыг энэ тайлангийн төгсгөл хэсгээс үзэж болно.

- **Иргэний нийгэм, төр засаг, салбарын төлөөлөлтэй хийсэн ярилцлага**

ББЗХ нь төрийн байгууллагын албан хаагчид, уул уурхайн тэргүүлэх компаниуд, холбоодын төлөөлөгчид, АМГТГ-ын ажилтнууд, Монголын Улс дах иргэний нийгмийн орон зайн талаар гүнзгий мэдлэгтэй зарим иргэний нийгмийн төлөөлөлтэй 2023 оны 12-р сарын 11-20-ний өдрүүдэд цуврал уулзалт хийв. Уул уурхайн салбарт иргэний нийгмийн гүйцэтгэх үүрэг ролийн хэтийн төлөвийг тодорхойлох, ялангуяа иргэний нийгмийн үүрэг ролийг сайжруулах, төр засаг, уул уурхайн компаниуд, ИНБ-уудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тулгардаг бэрхшээл, боломжуудыг олж тогтоох нь эдгээр уулзалтуудын үндсэн зорилго байсан юм.

- **Мэдээллийн цэвэрлэгээ, дүн шинжилгээ, график дүрслэл**

Холбогдох мэдээллийн судалгаа, фокус бүлгийн уулзалтууд, ярилцлага, асуумж судалгааны мэдээллүүдэд дүн шинжилгээ хийхэд тоон болон чанарын аргуудыг ашиглав. Дүн шинжилгээний хүрээнд мэдээллийн хэв шинж, сэдэв, хандлагыг тодорхойлоход голлон анхаарал хандуулж, уул уурхайн салбар дах иргэний нийгмийн орон зайг сайжруулах бүлэг зөвлөмжийг боловсруулахдаа ашиглав. Судалгааны бүх мэдээллийг R-программ ашиглан цэвэрлэж, мэдээллийг харагдах хэлбэрт оруулахын тулд хүснэгт, хөндлөн хүснэгтийн аргыг ашигласан. Үүний дараа мэдээллийг, хүссэн этгээд өөрийн аливаа зорилгод нийцүүлэн ашиглах, хувилах боломжтой илүү цэвэрхэн хэлбэр рүү хөрвүүлсэн.

Уул уурхайн салбар, уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах иргэний нийгмийн үйл ажлын аль алиных нь талаар нарийн мэдээлэл өгсөн энэ үнэлгээний ажлын аргачлалыг боловсруулах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажлыг 2023 оны 9-р сарын дундаас 12-р сар хүртэлх маш богино хугацаанд хийж гүйцэтгэсэн юм. Цаг хугацаа ийн давчуу байснаас ББЗХ уулзахыг хүсэж байсан зарим хувь хүмүүс, байгууллагатай уулзаж чадаагүй. Гэвч, хамгийн гол оролцогч талуудтай уулзаж зөвшилцөж, гол баримт бичгүүдийг судалж зохих дүн шинжилгээг хийсэн болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


2. Судалгааны гол үр дүнгүүд

2.1. Хувьсан өөрчлөгдөж буй олон хэв шинжит иргэний нийгэм

Уул уурхайн засаглалын асуудлаар ажилладаг иргэний нийгэм нь гарал үүсэл, үйл ажиллагаа, эрхэлсэн хугацаа, чадавх, гол анхаарлын бүс нутаг зэрэг бусад олон үзүүлэлтүүдээр ялгаатай бүлгүүдээс бүрдэнэ. Эдгээр ялгаатай чанаруудыг судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээллээс харж болох ба заримыг нь энэ бүлэгт үзүүлээ.


ИНБ-ууд албан ёсоор бүртгэгдсэн эсэхийг Зураг 3-т харуулав. Дийлэнх ИНБ-ууд ТББ хэлбэрээр албан ёсны бүртгэлтэй байдаг ч, Монгол Улсын хуулиар иргэний нийгмийг албан ёсоор бүртгүүлэлгүйгээр үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг. Үүний тод жишээ бол Төлсөн авснаа нийтэл (ТАН) эвсэл юм. Улсын бүртгэлтэй 20 гаруй ТББ-ыг эгнээндээ нэгтгэсэн ТАН эвсэл өөрөө ТББ-ын албан бүртгэлгүй.

Зураг 3. Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын бүртгэлийн байдал



Төрийн бус байгууллагууд нийгэмд үйлчлэх, гишүүддээ үйлчлэх гэсэн үндсэн хоёр чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Судалгаанд оролцогч ТББ-уудын үйл ажиллагааны чиглэлийг Зураг 4-т харуулав. Зарим ТББ-уудын үйл ажиллагааны чиглэл тодорхой бус байна.

Зураг 4. Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын үйл ажиллагааны чиглэл



ИНБ-ууд орон нутгийн болон үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг. Судалгаанд оролцсон ТББ-уудын үйл ажиллагааны үндсэн бүс нутгийг Хүснэгт 2-т харуулав. Дийлэнх ТББ-ууд үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулдаг ажээ.

Хүснэгт 2. ИНБ-уудын гол анхаарлын бүс нутаг

Үйл ажиллагааны чиглэл		ИНБ-уудын тоо
Нэг чиглэлт		
үндэсний хэмжээнд		24
аймагт		5
бүсийн хэмжээнд		3
бусад		2
суманд		1
Бүлгийн дүн	—	35
Олон чиглэлт		
үндэсний, аймгийн хэмжээнд		3
үндэсний, бүсийн хэмжээнд		3
аймаг, сумын хэмжээнд		1
бүсийн хэмжээнд, бусад		1
сумын хэмжээнд, бусад		1
үндэсний хэмжээнд, бусад		1
үндэсний, бүсийн хэмжээнд, бусад		1
үндэсний, бүсийн, аймгийн хэмжээнд		1
Бүлгийн дүн	—	12
Нийт дүн	—	47

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


Улаанбаатар нь Монгол Улсын бизнес, улс төр, эдийн засгийн төв ба, судалгаанд хамрагдсан ИНБ-уудын ихэнх нь нийслэлд үйл ажиллагаа явуулдаг (Хүснэгт 3). Улаанбаатар хотоос гадуур үйл ажиллагаа явуулах тохиолдолд, үйл ажиллагааг Улаанбаатар дах төв оффисоос шууд удирдах, эсвэл маш ховор тохиолдолд орон нутгийн салбар, эсвэл хамтрагч байгууллагаар дамжуулан хэрэгжүүлдэг.

Хүснэгт 3. ИНБ-уудын газар зүйн байршил

Газар зүйн байрлал	ИНБ-ын тоо
Улаанбаатар	22
Улаанбаатар ба орон нутгийн салбар	10
Улаанбаатар ба орон нутгийн хамтрагч	10
Аймгийн төв	3
Бусад	1
Улаанбаатар, орон нутгийн салбар болон хамтрагч	1


Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын үйл ажиллагаа эрхэлсэн хугацаа харилцан адилгүй байлаа. Хамгийн удаан үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага байгуулагдаад 31 жил болж байгаа бол хамгийн залуу нь хоёр жилийн өмнө байгуулагджээ. Судалгаанд хамрагдсан ИНБ-ууд байгуулагдсан хэдэн жил болж байгааг Зураг 5-д үзүүлсэн бөгөөд ихэнх нь олон жилийн туршлагатай байгууллагууд ажээ.

Зураг 5. ИНБ-уудын байгуулагдсан огноо, таван жилээр




Судалгаанд хамрагдсан байгууллагууд үйл ажиллагаа эрхэлсэн хугацаанаас гадна, хэмжээгээрээ буюу орон тооны ажиллагсдынхаа тоогоор ихээхэн ялгаатай байна. Ихэнх ИНБ-үүд хэмжээгээр жижиг буюу зөвхөн 7 нь 11-с дээш ажилтантай ба 32 нь таваас доош ажилтантай гэж мэдүүлжээ (Зураг 6).

Зураг 6. ИНБ-уудын орон тооны ажилтны тоо



Ажиллагсдын хүйсийн харьцааг авч үзвэл харьцангуй тэнцвэртэй буюу судалгаанд хамрагдсан 46 ИНБ-ын 24-д нь нийт ажиллагсдын 60-с дээш хувь нь эмэгтэйчүүд байна (Зураг 7).

Зураг 7. ИНБ-ын ажиллагсдын хүйсийн харьцаа




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Судалгаанд оролцсон ИНБ-уудын удирдлагуудын насыг

Зураг 8-д үзүүлэв. Байгууллагуудын удирдлагуудын дийлэнх нь 35-с дээш насны туршлагатай менежерүүд байна.


Зураг 8. ИНБ-уудын удирдлагын хамрах насны бүлэг



Судалгаанд хамрагдсан ИНБ-уудын удирдлагуудын хүйсийн харьцааг Зураг 9-д харуулав. 47 ИНБ-ын 34 нь эмэгтэй удирдлагатай байна.


Зураг 9. ИНБ-уудын удирдлагын хүйсийн харьцаа






Судалгаанд оролцсон ИНБ-уудын жилийн төсвийг авч үзвэл, ихэнх нь 200 сая төгрөгөөс доош төсөвтэй жижгэвтэр байгууллагууд, мөн 10 сая төгрөгөөс доош жилийн төсөвтэй 10 байгууллага байна. Энэ нь санхүүгийн асуудал ИНБ-уудын хувьд томоохон бэрхшээл болдгийг илтгэнэ.

Зураг 10. ИНБ-уудын жилийн төсөв




Санхүүжилтийн талаарх асуултад 41 байгууллага санхүүжилтийнхээ гол эх үүсвэрийг хэлсэн бол, 25 нь санхүүгийн 2 эх үүсвэртэй, 17 нь 3 дах эх үүсвэртэй гэж хариулжээ. Санхүүжилтийн гол эх үүсвэрт хувийн хэвшлийн олон улсын сангуудын нэр хамгийн олонтоо дурдагдсан байна.

Зураг 11. ИНБ-уудын санхүүжүүлэгчид




Буцалтгүй тусламж, хандиваас гадна зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар санхүүжилтээ босгох нь ИНБ-уудад өөрийн тэргүүлэх зорилт, стратегид төвлөрөхөөс илүү хандивлагчийн зорилтод төвлөрөх нөлөөтэйг Зураг 12-с харж болно. Нийт ИНБ-уудын талаас илүү нь зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд эдгээр байгууллагуудын нэлээд хэсэг нь нийт ажлынхаа талаас илүү хувийг зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд зориулдаг байна.

Зураг 12. ИНБ-уудын үзүүлдэг зөвлөх үйлчилгээ, үндсэн үйл ажиллагаанд эзлэх хувиар



Асуумжийн судалгаанд хамрагдсан 47 байгууллагын 23 нь бусдад зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил эрхлээгүй бол, 2022 оны байдлаар 24 нь дор хаяж 35 өөр байгууллагад зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна. ИНБ-аас зөвлөх үйлчилгээ авсан байгууллагуудын төрлийг Зураг 13-с үзнэ үү.


Зураг 13. ИНБ-аас зөвлөх үйлчилгээ авдаг харилцагчид



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Нийт 47 байгууллагын 36 нь буюу 76.6 хувь нь дор хаяж нэг эвсэл, сүлжээнд гишүүнээр элссэн, эвсэл харьяалагддаг гэж мэдүүлсэн. Судалгаанд оролцсон ИНБ-уудын харьяалагддаг иргэний нийгмийн гол эвсэл, сүлжээг Зураг 14-д харууллаа. Тэдгээрийн хамгийн том нь Монгол Улсын ОУИТБС-ын иргэний нийгмийн гол хамтрагч болох ТАН эвсэл, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, жендэрийн асуудал эрхэлсэн ТББ-уудын толгой байгууллага болох Монфемнет байлаа.

Зураг 14. ИНБ-уудын эвсэл, холбоо




ИНБ-үүд уул уурхайн бодлого, засаглалын асуудалд оролцоходоо харилцан адилгүй асуудлуудад гол анхаарлаа хандуулдаг байна. ИНБ-уудын хувьд гол ач холбогдолтой гэж үзсэн тэргүүлэх чиглэлүүдийг

Зураг 15-д үзүүлэв. Тэдгээрт, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, нутгийн иргэдийн ашиг сонирхол, байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн нөлөөлөл, хүний эрх, жендэрийн асуудлууд оржээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 15. ИНБ-уудын уул уурхайн засаглалтай холбоотой үйл ажиллагааны гол чиглэлүүд



Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг ИНБ-уудыг үйл ажиллагааны чиглэлийг цааш судлав (

Хүснэгт 4). Хүний эрх, жендэрийн тэгш байдал, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, байгаль орчин, нийгэмд уул уурхайн үзүүлэх нөлөөллийн асуудалд гол анхаарах шаардлагатай гэж ИНБ-ууд үзсэн байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


Хүснэгт 4. Уул уурхайн засаглалын чиглэлээр ажиллаж буй ИНБ-уудын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Гол чиглэл	ИНБ-ын тоо
Эрэмбэ 1	
Ил тод байдал	9
Хүний эрх ба жендер	9
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	7
Бусад	4
Орон нутгийн ашиг сонирхол	4
Лиценз олголт	2
Татвар, төсвийн орлого	1
Уул уурхайн гэрээ	1
Эрчим хүчний шилжилт	1
Эрэмбэ 2	
Орон нутгийн ашиг сонирхол	7
Хүний эрх ба жендер	5
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	4
Авлигатай тэмцэх	3
Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт	2
Бусад	2
Лиценз олголт	2
Төрийн өмчит компани	2
Уул уурхайн гэрээ	2
Эрчим хүчний шилжилт	2
Ил тод байдал	1
Эрэмбэ 3	
Орон нутгийн ашиг сонирхол	8
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	5
Ил тод байдал	5
Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт	3
Лиценз олголт	2
Төрийн өмчит компани	2
Уул уурхайн гэрээ	2
Авлигатай тэмцэх	1
Хүний эрх ба жендер	1
Эрчим хүчний шилжилт	1
Эрэмбэ 4	
Ил тод байдал	5
Эрчим хүчний шилжилт	4
Авлигатай тэмцэх	3
Татвар, төсвийн орлого	3
Төрийн өмчит компани	3
Хүний эрх ба жендер	3
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	2
Уул уурхайн гэрээ	2
Лиценз олголт	1
Орон нутгийн ашиг сонирхол	1
Эрэмбэ 5	
Авлигатай тэмцэх	4
Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт	4
Орлогын менежмент	4
Эрчим хүчний шилжилт	4
Ил тод байдал	3
Лиценз олголт	3
Татвар, төсвийн орлого	3
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	2
Уул уурхайн гэрээ	2
Хүний эрх ба жендер	1



Уул уурхайн засаглалын чиглэлээр ажилладаг ИНБ-уудын үйл ажиллагаа нь олон хэлбэртэй байна (Зураг 16). Бодлогын түвшний нөлөөллийн үйл ажиллагаа, оролцогч талуудын үйл ажиллагаанд оролцох, хамтран ажиллах, бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, ил тод байдлыг дэмжих кампанит ажил зохион байгуулах, өгөгдөл ашиглах, бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх зэрэг ажлууд хамгийн олонтоо дурдагдсан байна.

Зураг 16. Уул уурхайн засаглал дахь ИНБ-уудын оролцооны хэлбэрүүд



Үйл ажиллагааны ашиглаж буй арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл, бодлогын түвшин дэх нөлөөллийн ажил, ил тод байдлыг дэмжих кампанит ажлууд бусдаас арай илүү санал авсан байна. Үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлснийг Хүснэгт 5-с үзнэ үү.

Хүснэгт 5. ИНБ-уудын уул уурхайн засаглал дахь үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн байдал

Ашиглах арга хэрэгсэл	ИНБ-ын тоо
Эрэмбэ 1	
Бодлогын нөлөөлөл	9
Ил тод байдлын кампани	7
Талуудтай хамтрах ба оролцоо	6
Өгөгдөл ашиглалт ба бодлогын судалгаа	6
Бодлогын хэрэгжилтийн мониторинг	4
Нийтийн эрх ашгийн өмгөөлөл	3
Бусад	1
Эрэмбэ 2	
Ил тод байдлын кампани	8
Талуудтай хамтрах ба оролцоо	8
Бодлогын нөлөөлөл	5
Бодлогын хэрэгжилтийн мониторинг	5
Өгөгдөл ашиглалт ба бодлогын судалгаа	4
Нийтийн эрх ашгийн өмгөөлөл	3
Эрэмбэ 3	
Өгөгдөл ашиглалт ба бодлогын судалгаа	9
Бодлогын нөлөөлөл	8
Бодлогын хэрэгжилтийн мониторинг	8
Ил тод байдлын кампани	4
Талуудтай хамтрах ба оролцоо	3
Бусад	1
Нийтийн эрх ашгийн өмгөөлөл	1
Эрэмбэ 4	
Бодлогын нөлөөлөл	9
Бодлогын хэрэгжилтийн мониторинг	7
Талуудтай хамтрах ба оролцоо	7
Ил тод байдлын кампани	2
Бусад	1
Өгөгдөл ашиглалт ба бодлогын судалгаа	1
Эрэмбэ 5	
Талуудтай хамтрах ба оролцоо	7
Бусад	5
Бодлогын нөлөөлөл	4
Ил тод байдлын кампани	4
Нийтийн эрх ашгийн өмгөөлөл	4
Бодлогын хэрэгжилтийн мониторинг	3
Өгөгдөл ашиглалт ба бодлогын судалгаа	3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2.2. Ил тод байдал, нутгийн иргэдийн ашиг сонирхлыг эн тэргүүнд

Уул уурхайн бодлого, засаглалын олон асуудлаар ИНБ-үүд удаан хугацаанд идэвхтэй ажилласаар ирсэн. Тэдгээрийн дундаас, нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, хүний эрх, жендэрийн асуудал, байгаль орчин, нийгэмд уул уурхайн үзүүлэх нөлөөллийн асуудалд ИНБ-үүд тэргүүлэх ач холбогдол өгч иржээ (Хүснэгт 6). Авлигатай тэмцэх, орлогын удирдлагын асуудлууд ИНБ-үүд болон тэдгээрийн үйл ажиллагаанд төдийлөн чухал байр суурь эзлэхгүй байгаа нь энэ талын мэргэшил, эх үүсвэр дутмаг байгаагийн илрэл гэж үзэж байна.

Хүснэгт 6. Уул уурхайн засаглалын ИНБ-үүдын оролцоотой бодлогын асуудлууд

Бодлогын чиглэл	ИНБ-ын тоо
Орон нутгийн ашиг сонирхол	22
Ил тод байдал	21
Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл	20
Хүний эрх ба жендер	20
Уул уурхайн гэрээ	11
Лиценз олголт	11
Эрчим хүчний шилжилт	11
Татвар, төсвийн орлого	10
Бусад	9
Төрийн өмчит компани	8
Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт	7
Орлогын менежмент	6
Авлигатай тэмцэх	4

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал, байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл, нутгийн иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, хүний эрх, жендэрийн асуудлуудыг иргэний нийгмийн төвлөрөх зохих чиглэлүүд гэж ИНБ-үүд үзжээ (Хүснэгт 7). Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх үндэсний түвшинд сайжирсан ч, хариуцлагатай байдалд төдийлөн ахиц гараагүй. Нээлттэй болгосон мэдээллийн чанар ард түмний хэрэгцээг шаардлагыг хангадаггүй, өөр өөр эх сурвалжаас авсан боловсруулалт хийгдээгүй мэдээ, мэдээлэл нь ихэнхдээ хоорондоо зөрдөг, ба олон нийтийг төөрөгдөлд оруулдаг нь мэдээ, мэдээллийн нэгдсэн стандарт байхгүйтэй холбоотой. Ийм нөхцөлд, тэдгээр мэдээллийг боловсруулах, иргэдэд дамжуулах сувгийн үүргийг зарим ИНБ гүйцэтгэдэг. Түүнчлэн, мэдээлэл цуглуулах цаг хугацаа, мэдээллийг нэгдсэн байдлаар гаргадаг зэргээс шалтгаалан үндэсний түвшний мэдээлэл орон нутгийн бодит байдалтай тэр бүр тохирдоггүй нь ажиглагдлаа. Заримдаа, ИНБ-үүд уул уурхайн бүс нутгийн хүн амын дунд болсон үйл явдлын талаар илүү бодит, дэлгэрэнгүй мэдээллийг эх сурвалжаас нь шууд авах талаар илүү үр дүнтэй байдаг ажээ.

Авлигатай тэмцэх ажил ИНБ-үүдын үйл ажиллагааны жагсаалтад дээгүүр байр эзэлдэг байж болох ч, ихэнхдээ өөр нэршлээр томъёологдсон байдгаас гадна нэмэлт эх үүсвэр, мэргэшил шаарддаг байна. Авлига ихэвчлэн, төрийн өмчийн уул уурхайн компаниудын хүрээнд орших ба, ярилцлагад

оролцсон зарим хүмүүсийн үзэж байгаагаар, уул уурхайн компаниудын засаглал, авлигатай тэмцэх явдал нь үндсэндээ нэг зоосны хоёр тал ажээ.

Хүснэгт 7. ИНБ-уудын төвлөрвөл зохих бодлогын чиглэлүүд

ИНБ-уудын төвлөрвөл зохих чиглэлүүд	ИНБ-ын тоо
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	22
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	19
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	15
Хүний эрх, жендерийн бодлого	13
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	11
Авлигатай тэмцэх	6
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	6
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	4
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	4
Уул уурхайн татвар, төсвийн орлого	4
Тусгай зөвшөөрөл	3
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	2
Бусад	1

Бодлогын чиглэлүүдийг эрэмбэлбэл, ИНБ-уудын хувьд хамгийн чухал асуудал нь байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн нөлөөлөл, хүний эрх, жендэрийн бодлого, мэдээллийн ил тод, нээлттэй байдал (

Хүснэгт 8) байна. Мөн хоёрдугаар эрэмбэд дээр тодорхойлсон ижил гурван асуудал орсон байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хүснэгт 8. ИНБ-уудын ажиллалал зохиох бодлогын тэргүүлэх чиглэлүүд

ИНБ-ууд ажиллалал зохиох чиглэлүүд	ИНБ-ын тоо
Эрэмбэ 1	
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	10
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	7
Хүний эрх , жендерийн бодлого	7
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	6
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	4
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	2
Авлигатай тэмцэх	1
Тусгай зөвшөөрөл	1
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	1
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	1
Эрэмбэ 2	
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	8
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	5
Хүний эрх , жендерийн бодлого	5
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	3
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	3
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	2
Тусгай зөвшөөрөл	2
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	2
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	2
Авлигатай тэмцэх	1
Бусад	1
Уул уурхайн татвар, төсвийн орлого	1
Эрэмбэ 3	
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	12
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	5
Авлигатай тэмцэх	4
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	4
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	3
Уул уурхайн татвар, төсвийн орлого	3
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	2
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	1
Хүний эрх , жендерийн бодлого	1



Судалгаанд оролцогчид эрчим хүчний шилжилт, уур амьсгалын өөрчлөлтийн асуудлууд, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, байгаль орчин, нийгэмд үзүүлэх уул уурхайн нөлөөллийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн (Хүснэгт 9). Эдгээрээс, нэгдүгээрт эрчим хүчний шилжилтийн асуудал иргэний нийгмийн хувьд шинэ чиглэл тул энэ талаар чадавх хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдана.

Хүснэгт 9. ИНБ-уудын ажиллахыг хүсэж бодлогын чиглэлүүд

Ажиллахыг хүсэж буй чиглэлүүд	ИНБ-ын тоо
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	15
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	12
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	10
Авлигатай тэмцэх	9
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	8
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	8
Уул уурхайн татвар, төсвийн орлого	7
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	6
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	6
Хүний эрх, жендерийн бодлого	6
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	5
Бусад	3
Тусгай зөвшөөрөл	3

Түүнчлэн, ИНБ-уудын ажиллахыг хүссэн чиглэлүүдийн эрэмбэлснээс харахад эрчим хүчний шилжилт, уур амьсгалын өөрчлөлт, уул уурхайн салбарын ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, авлигатай тэмцэх ажлууд гол байруудыг эзэлжээ. ИНБ-уудын ажиллахыг хүссэн бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн жагсаалтыг



Хүснэгт 10-т үзүүлэв. Өөрсдийн төлөөлдөг хүн амын бүлгийн хувьд аль нь илүү чухал вэ гэдгээс хамааран, дээрх чиглэлүүдийн талаар орон нутаг, үндэсний түвшний ИНБ-ууд өөр өөр байр суурьтай байгаа нь ажиглагдсан. Иймд, эдгээр чиглэлүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд нэлээд болгоомжтой хандах нь зүйтэй.

Хүснэгт 10. ИНБ-уудын ажиллахыг хүссэн бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Ажиллахыг хүсэж буй чиглэлүүд	ИНБ-ын тоо
Эрэмбэ 1	
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	8
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	6
Авлигатай тэмцэх	5
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	4
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	4
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	3
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	3
Бусад	2
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	2
Хүний эрх , жендерийн бодлого	2
Тусгай зөвшөөрөл	1
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	1
Уул уурхайн татвар, төсвийн орлого	1
Эрэмбэ 2	
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	4
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	4
Авлигатай тэмцэх	3
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	3
Хүний эрх , жендерийн бодлого	3
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	2
Тусгай зөвшөөрөл	2
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	2
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	2
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	1
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	1
Эрэмбэ 3	
Уул уурхайн татвар, төсвийн орлого	6
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	6
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	5
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	3
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	2
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	2
Авлигатай тэмцэх	1
Бусад	1
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	1
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	1
Хүний эрх , жендерийн бодлого	1



2.3. Чадавхаа хөгжүүлэх, нарийн мэргэшэх нь иргэний нийгмийн нэн тэргүүний зорилт

Дийлэнх ИНБ-ын уул уурхайн засаглал дах оролцоо цөөн хэдэн асуудлаар хязгаарлагддаг бол зарим ИНБ-ууд өнгөрсөн гурван жилийн хугацаанд 10 хүртэлх асуудалд оролцож иржээ (Хүснэгт 11). Олонх ИНБ-ууд нэгэн зэрэг хэд хэдэн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг нь санхүүжилтийн дутмаг байдал, ялангуяа өөр өөр эх үүсвэрээс жижиг санхүүжилт авч байгаа нөхцөлд, санхүүжүүлэгчийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай болдогтой холбоотой байж болзошгүй.

Хүснэгт 11. Иргэний нийгмийн оролцоотой, уул уурхайн засаглалтай холбоотой бодлогын асуудлын тоо

Арга хэрэгслийн тоо	ИНБ-ын тоо	
1	10	
2	8	
3	6	
4	6	
5	5	
6	3	
7	2	
8	2	
9	1	
10	1	

Бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг, оролцогч талуудын оролцоо ба төлөөлөл гэсэн хоёр асуудал сүүлийн гурван жилийн хугацаанд ИНБ-уудын явуулсан үйл ажиллагааны хамгийн түгээмэл хэлбэр байсан бол, стратегийн өмгөөллийн асуудлыг ИНБ-ууд өөрийн зорилгод төдийлөн өргөн ашиглаагүй байна (Хүснэгт 12).

Хүснэгт 12. ИНБ-уудын үйл ажиллагааны хамгийн түгээмэл арга хэрэгслүүд

Ашиглах арга хэрэгсэл	ИНБ-ын тоо	
Бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг	26	
Оролцогч талуудын оролцоо ба төлөөлөл	24	
Бодлогын хэрэгжилтэд тавих хяналт	16	
Мэдээллийн ил тод байдлын кампанит ажил	16	
Дата ашиглалт, бодлогын судалгаа, дүн шинжилгээ	13	
Стратегийн өмгөөлөл	7	
Бусад	5	

UIH.MN
СЭЗЭЛГ ААНЫ САН

ИНБ-уудын үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг эрэмбэлэн цааш задалж үзвэл (Хүснэгт 13) бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг нь эрэмбээрээ тэргүүн болон удаах байранд эрэмбэлэгдэж байгаа бол оролцогч талуудыг оролцоо ба төлөөлөл нь олон ИНБ-ууд хувьд удаах байранд эрэмбэлэгдэж байна. Маш үр дүнтэй ажил болох ч, стратегийн өмгөөллийн ажлыг ховорхон ашиглаж байгаа нь түүнийг хэрэгжүүлэх нарийн мэргэшил, үр чадвар ИНБ-уудад дутмаг байгаатай холбоотой. Энэ чиглэлээр ажилладаг цөөн хэдэн ИНБ-уудын үйл ажиллагаа ч гэсэн шүүхийн танхимаас хэтэрч чадахгүй байгаа ба мэдээлэл хүргэх, нөлөөллийн арга хэмжээг ашиглахгүй байгаа нь санхүүгийн эх үүсвэр дутмагтай холбоотой. Өгөгдөл ашиглах, бодлогын судалгаа, дүн шинжилгээ хийх ажил ИНБ-уудад бараг явагдахгүй байгаа нь мөн л нарийн мэргэшил, эх үүсвэр дутмаг байгаагаас үүдэлтэй байна. Гэхдээ, эдгээр нь маш чухал үйл ажиллагаанууд бөгөөд энэ чиглэлээр хийх ажлуудыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатай.

ИНБ-ын ямар ч үйл ажилд иргэдийн оролцоо амин чухал. Бэрхшээл нэмэгдэж, улам ээдрээтэй болох тусам, хэчнээн бэлтгэлтэй, төлөвлөгөөтэй байсан ч гэсэн, зарим нөхцөлд ИНБ-ууд олон асуудлуудыг үр дүнтэй удирдах боломжгүй болдог. Энэ нөхцөлд зорьсон үр дүндээ хүрэхийн тулд тэдэнд олон нийтийн оролцоо хэрэг болно. ИНБ нь иргэдийн оролцоог хангах гүүр болж чадна.



Хүснэгт 13. ИНБ-уудын үйл ажиллагааны арга хэрэгслүүдийг ач холбогдлоор нь эрэмбэлсэн нь

Ашиглах арга хэрэгсэл	ИНБ-ын тоо
Эрэмбэ 1	
Бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг	15
Мэдээллийн ил тод байдлын кампанит ажил	8
Оролцогч талуудын оролцоо ба төлөөлөл	6
Дата ашиглалт, бодлогын судалгаа, дүн шинжилгээ	5
Стратегийн өмгөөлөл	3
Бодлогын хэрэгжилтэд тавих хяналт	2
Бусад	2
Эрэмбэ 2	
Оролцогч талуудын оролцоо ба төлөөлөл	10
Бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг	8
Бодлогын хэрэгжилтэд тавих хяналт	6
Дата ашиглалт, бодлогын судалгаа, дүн шинжилгээ	5
Мэдээллийн ил тод байдлын кампанит ажил	5
Бусад	1
Стратегийн өмгөөлөл	1
Эрэмбэ 3	
Бодлогын хэрэгжилтэд тавих хяналт	8
Оролцогч талуудын оролцоо ба төлөөлөл	8
Бодлогын нөлөөлөл ба хэлэлцүүлэг	3
Дата ашиглалт, бодлогын судалгаа, дүн шинжилгээ	3
Мэдээллийн ил тод байдлын кампанит ажил	3
Стратегийн өмгөөлөл	3
Бусад	2



2.4. Иргэний нийгмийн ачаар олон асуудлыг өөрчилж чадсан

Иргэний нийгмийн олон хэв шинж, амжилт гаргаж буй олон ИНБ-уудыг уул уурхайн засаглалын хүрээнд хүлээн зөвшөөрдөг. Тэдгээр ИНБ-ууд хэрхэн амжилтад хүрснийг ойлгох нь тэдний үйл ажиллагаа явуулдаг орчныг ойлгож мэдэхэд нэн чухал юм.

Нутгийн иргэдийн эрх ашгийг хамгаалах, хүний эрх, жендерийн асуудал, төрийн өмчит компанийн үйл ажиллагаанд хяналт тавих талаар өнгөрсөн хугацаанд хүрсэн амжилтын түүх арвин байна (Хүснэгт 14). Зарим ИНБ-ууд, шийдвэр гаргах, бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа дах иргэдийн оролцоог нэмэгдүүлж, тэдний амьжиргааг дээшлүүлэхэд томоохон амжилт гаргажээ.

Хүснэгт 14. ИНБ-уудын амжилттай ажилласан бодлогын чиглэлүүд

ИНБ-ууд амжилттай ажиллаж ирсэн чиглэлүүд	ИНБ-ын тоо
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	24
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	23
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	17
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	9
Тусгай зөвшөөрөл	9
Хүний эрх, жендерийн бодлого	6
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	6
Уул уурхайн татвар, төсвийн орлого	5
Бусад	3
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	3
Авлигатай тэмцэх	2
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	2
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	1

Амжилттай ажилласан бодлогын чиглэлүүдийг эрэмбэлбэл, дээрхтэй ижил дүр зураг харагдаж байна. ИНБ-уудын амжилттай ажилласан бодлогын чиглэлүүдийг эрэмбэлснийг Хүснэгт 15-д үзүүлэв. Нутгийн иргэдийн ашиг сонирхол дээрх хүснэгтийн гурван эрэмбийн жагсаалтад жигд өндөр байгааг харж болно.

Хүснэгт 15. ИНБ-уудын амжилттай ажилласан бодлогын чиглэлүүдийг эрэмбэлсэн нь

ИНБ-уудын амжилттай ажилласан чиглэлүүд	ИНБ-ын тоо	
Эрэмбэ 1		
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	12	
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	11	
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	8	
Тусгай зөвшөөрөл	3	
Бусад	2	
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	2	
Уул уурхайн татвар, төсвийн орлого	2	
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	1	
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	1	
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	1	
Эрэмбэ 2		
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	9	
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	7	
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	6	
Хүний эрх , жендерийн бодлого	4	
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	3	
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	2	
Тусгай зөвшөөрөл	1	
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	1	
Уул уурхайн орлогын удирдлага, ашиглалт	1	
Уул уурхайн татвар, төсвийн орлого	1	
Эрэмбэ 3		
Орон нутгийн иргэдийн ашиг сонирхол	5	
Тусгай зөвшөөрөл	5	
Засгийн газар болон уул уурхайн компаниудын хооронд байгуулсан гэрээ	4	
Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө	3	
Ил тод байдал ба мэдээлэл авах эрх	3	
Үйл ажиллагаа, эрүүл мэнд, аюулгүй байдлын стандартууд	3	
Авлигатай тэмцэх	2	
Уул уурхайн татвар, төсвийн орлого	2	
Хүний эрх , жендерийн бодлого	2	
Бусад	1	
Төрийн өмчит уул уурхайн компаниуд	1	
Эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлт	1	



Нийтийн эрх ашгийн өмгөөлөл, байгаль орчны менежмент, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, орон нутгийн эрх ашиг зэрэг чиглэлээр хэрэгжсэн төслүүдийг хамгийн том амжилтад хүрсэн гэж олон оролцогч үзжээ. Мөн, ОУИТБС, ТАН хөдөлгөөнийг амжилтын түүхээр нэрлэж, Нээлттэй нийгэм хүрээлэн, Хүний эрх хөгжил төв, Глоб Интернэшнл, Оюу толгой хяналт зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа нь амжилттай яваа гэж дүгнэжээ. Оролцогчдын хариулсан байдлыг үгэн үүлээр харуулав (Зураг 17).

Зураг 17. Амжилттай хэрэгжсэн төслүүдийн үйл ажиллагааны чиглэл



Төрийн буруу шийдвэрийг засахад иргэний нийгэм хэрхэн амжилттай оролцсон, мөн энэ нь амар хялбар байгаагүйг харуулсан нэг жишээ бол Монгол Улсын хоёр аймгийн нутагт олгогдсон ураны тусгай зөвшөөрлийн асуудлаар Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын эсрэг нийтийн эрх ашгийн өмгөөллийн асуудлаар шүүхэд хандсан Их бага Баяншарга ТББ-ын Л.Борын жишээ юм. Тэрээр Дундговь аймгийн нутагт, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газрын зөвшөөрөл авах ёстой зэрэг хуулийн хэд хэдэн заалтуудыг зөрчин Гурвансайхан ХХК-д олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах асуудлаар шүүхэд хандсан.²⁹ Шүүх нэхэмжлэлийг ИНБ-ын талд шийдвэрлэж, тухайн компанид олгогдсон зөвшөөрлийг цуцалсан байдаг. Тэмцлийнхээ үр дүнг үзэхийн хажуугаар, санхүүжилт олох, хуулийн мэргэжилтнүүдээс дэмжлэг авах, хэрэг шийдвэрлэх сунжирсан урт процессыг туулах гээд олон бэрхшээлийг давж гарснаа өөрийн социал хуудас болон, хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурдсан байдаг. Мөн, хууль сахиулах байгууллагад өөрийн үйл ажиллагааны талаар байцаагдаж байхдаа хууль сахиулах байгууллагын ажилтнуудын зүгээс хонзогнох, айлган сүрдүүлэх явдалд өртөж байснаа цухуйлгаснаас гадна, ТББ-ын нэр зөрснөөс болж (шинээр гарсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу “сан” нэртэй байгууллага уг хуулиар зохицуулагдах болсон тул ТББ-үүд


²⁹ Шүүхийн шийдвэрийн мэдээллийн сан “Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр”

“сан” гэдэг үгийг нэрнээсээ хасаж, улсын бүртгэлд өөр нэрээр дахин бүртгүүлсэн) хариуцагч компани нэхэмжлэлийг цуцлуулах оролдлого хийж байсан тухай ярьжээ.³⁰

2.5. ИНБ-уудын үйл ажиллагааны үндэс нь үр дүнтэй оролцоо, түншлэл

Уул уурхайн бодлого, засаглалын төслүүдэд ажиллах явцдаа ИНБ-ууд янз бүрийн оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах шаардлагатай болдог. Судалгаанд хамрагдсан ИНБ-ууд голдуу бусад ИНБ, төрийн болон хандивлагч, олон улсын байгууллагууд, орон нутгийн иргэдтэй харьцдаг байна. Бусад оролцогч талуудтай харьцах давтамжийг Зураг 18-д эрэмбэлэн үзүүлээ. ИНБ-уудын хувьд хамгийн их харьцдаг, чухал оролцогч талын хоёрдугаар эрэмбэд уул уурхайн компаниуд орсон нь сонирхолтой байлаа.

Зураг 18. ИНБ-уудын хамтрагч талууд, сүүлийн гурван жилийн байдлаар




Нөгөө талаас, хамтын ажиллагааны эрч ИНБ-ууд болон төрийн байгууллага, сэтгүүлчдийн дунд хамгийн сул байна (

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

³⁰ Л.Бор, Фейсбүүкийн нийтлэл


Зураг 19). Ялангуяа, төр, иргэний нийгмийн харилцаа маш хязгаарлагдмал байгааг сайжруулах шаардлагатай байна. Түүнээс гадна, төрийн байгууллага, тухайлбал гол яамдын албан хаагчид байнга солигддог, түүнийг дагаад төрийн байгууллагуудын нээлттэй байдал, хамтран ажиллах хүсэл сонирхол өөрчлөгддөг, энэ мэт төрийн байгууллагуудын өөрчлөлт, тогтворгүй байдал нь нэг удаагийн явдал биш байнгын үзэгдэл болсныг хэлэхээс аргагүй. Мөн төрийн байгууллагуудын төсөв, санхүүгийн эх үүсвэр нэмэгдсэнээс ИНБ зэрэг гуравдагч оролцогч талуудтай нээлттэй хамтран ажиллах сонирхол нь буурчээ.

Зураг 19. ИНБ-уудтай сул хамтын ажиллагаатай оролцогч талууд, сүүлийн гурван жилийн байдлаар




ИНБ, төр засгийн харилцааны гол талбар нь төрийн байгууллагын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, төрийн албан хаагчтай хийх биечилсэн уулзалт, ОУИТБС зэрэг олон талт зөвлөлөөс зохион байгуулсан уулзалтууд байна. Албан ёсны цахим хуудас ч бас харилцааны талбарын үүрэг гүйцэтгэнэ. ИНБ, төр засгийн харилцааны сувгуудыг Зураг 20-д үзүүлэв. ИНБ-уудтай харьцах, эсвэл тэдний тавьсан хүсэлт, шаардлагыг хэрхэх талаар төрийн бус байгууллагуудтай харилцах дүрэм журам байдаггүйгээс гадна ИНБ-уудтай хэлэлцэх, санал солилцож болох асуудлуудыг хууль, бусад зохицуулалтаар хязгаарласан байх нь бий. Жишээ нь, ИНБ-уудын төр засгаас шаарддаг мэдээллүүд ихэнхдээ хувь хүний нууцтай холбоотой байх тул тэдгээр мэдээллийг өгөх төрийн байгууллагын эрх хязгаарлагдсан байх нь олонтоо.

Зураг 20. ИНБ, төр засгийн харилцааны сувгууд




ИНБ-ууд уул уурхайн бодлого, засаглалын олон асуудлаар уул уурхайн компаниудтай харьцдаг. Эдгээр харилцаа нь ихэвчлэн ОУИТБС зэрэг олон талт оролцогч талуудын түншлэлийн тавцан, албан ёсны цахим хуудас, компанийн төлөөлөлтэй нүүр тулсан уулзалтын хүрээнд явагдана (Зураг 21). ИНБ, уул уурхайн компаниудын харилцаа сүүлийн жилүүдэд сайжирсан, төсөлд хамтарсан хяналт тавих, мэдээлэл солилцох, ил тод байдлыг сайжруулах талаар ИНБ-уудын тавьдаг шаардлага, хүсэлтэд уул уурхайн зарим тэргүүлэх компаниуд нааштай ханддаг болсон гэж үзэх ИНБ олон байна. ИНБ-уудад арай нааштай ханддаг хэд нь голдуу гадаад хөрөнгө оруулалттай томоохон компани байдаг бол Монгол эзэнтэй жижиг, дунд компаниудтай хамтран ажиллахад илүү төвөгтэй байдаг ажээ. ИНБ-ыг, засаглалын зарим асуудлуудыг сайжруулахад хамтран ажиллах боломжийн түнш гэхээсээ илүүтэй, дайсан гэж үздэг албан тушаалтнууд уул уурхайн компаниудад олон байх ба тэд ИНБ-уудыг, ОУИТБС зэрэг олон талт түншлэлийн тавцангаас, эсвэл камерын өмнө уул уурхайн компаниудыг үндэслэл, нотлох баримтгүйгээр шүүмжилдэг этгээдүүд гэж үзэх нь олонтоо.

Зураг 21. ИНБ, уул уурхайн компанийн албан тушаалтнуудын харилцааны сувгууд




ИНБ-ууд хоорондоо идэвхтэй харилцдаг. Хамтрах, мэдээлэл солилцох болон бусад олон зорилготойгоор харилцдаг. Эдгээр харилцаа явагддаг гол орчин нь иргэний нийгмийн оролцоотой олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, нүүр тулсан уулзалт, цахим шүүдэн байдаг (



Зураг 22). Зохион байгуулалт муу, хамтарсан төсөл байхгүй, хүний нөөц, санхүүжилт дутмаг байснаас ИНБ-уудын олон түншлэл бүтэлгүйтсэн юм. Жишээ нь, эвсэл гишүүдийнхээ нөөц бололцоог бүрэн ашиглаж чадаагүй гэж ТАН эвслийн зарим гишүүд маш их бухимддаг. Тогтвортой үйл ажиллагаатай ИНБ орон нутагт бараг байдаггүйгээс үндэсний болон орон нутгийн түвшний ИНБ-уудын түншлэл төдийлөн амжилт олдоггүй байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 22. ИНБ хоорондын харилцааны сувгууд




Хандивлагч, олон улсын байгууллагууд, бусад ИНБ, уул уурхайн компани, төрийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх хүсэлтэйгээ судалгаанд оролцогчид илэрхийлсэн (дэлгэрэнгүйг

Зураг 23-с үзнэ үү). Иргэний нийгмийн үйл хэрэгт, ялангуяа засаглалын асуудлаар ажилладаг ИНБ-уудад хандивлагчийн санхүүгийн дэмжлэг маш чухал. Гэвч, Канадын СЕСМИМ, МЕРИТ зэрэг уул уурхайн засаглалын хөтөлбөрүүд дуусах, санхүүжилт зогсох, хандивлагчийн тэргүүлэх чиглэл өөрчлөгдсөн нөхцөлд ИНБ-хандивлагчийн түншлэл их сайндаа л мэдээлэл солилцохоос үл хэтэрнэ. Ер нь, ИНБ-хандивлагчийн хамтын ажиллагаа хандивлагчийн зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд оролцох төдийгөөр хязгаарлагдах ба тодорхой нэг дэмжлэг, түншлэлийг бий болгодоггүй ажээ.


Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ цацахад төлбөртэй байдгаас хэвлэл мэдээллийн салбар, сэтгүүлчидтэй хамтран ажиллахад хүндрэл үүсдэг. Нийгмийн сүлжээ нь мэргэжлийн мэдээллийн хэрэгслийг тодорхой хэмжээнд орлох чадвартай ч, мэдээллийг олон нийтэд жигд хүргэх талаар учир дутагдалтай байдаг.

Зураг 23. ИНБ-уудын зүгээс хамтын ажиллагаагаа эрчимжүүлэх хүсэлтэй оролцогч талууд



ИНБ-ууд байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө, ил тод, нээлттэй байдал ба мэдээлэл авах эрх, эрчим хүчний шилжилт ба уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаар түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй байна. Оролцогчдын дэлгэрэнгүй хариултыг Зураг 24-с үзнэ үү.

Зураг 24. ИНБ-уудын зүгээс хамтын ажиллагаагаа өргөжүүлэх хүсэлтэй бодлогын чиглэлүүд




2.6. Шинэ, хуучин сорилтуудыг шийдвэрлэхэд илүү сайн үйлдаа холбоо, хамтын ажиллагаа чухал

Уул уурхайн бодлого, засаглалын асуудлаар ажилладаг иргэний нийгэм олон сорилттой тулгардаг. Тэдгээр сорилтуудыг улам гүнзгий судлах, үйлдаа холбоо, хамтын ажиллагаагаа сайжруулахад ИНБ-ууд яагаад гол анхаарлаа хандуулах шаардлагатайг энэ бүлэгт авч үзнэ.

Хамгийн том сорилтуудыг эрэмбэлснээс харахад (Зураг 25), санхүүжилт, хүний нөөц, үр чадвар, гишүүн, дэмжигч элсүүлэлт, ба хамтын ажиллагаа түншлэл нэгдүгээрт эрэмбэлэгдсэн бол, стратеги боловсруулалт болон менежментийн асуудал хол тасархай хоёрдугаарт эрэмбэлэгджээ.


Санхүүжилт бол ИНБ-д тулгардаг хамгийн том сорилт гэдгийг хэн бүхэн мэднэ. Гэвч энэ талаар өөр үзэл бодол сонсогддог: түүнийг гол бэрхшээл гэж үздэг нэгэн байхад, нөгөө нь ИНБ-ын үр ашиг муутай үйл ажиллагааных нь үр дагавар ба, өөрийн орон зайг олж чадаж гэмээнэ хоёрдогч асуудал болон хувирна гэж үздэг. Ямартай ч, санхүүжилт муутай байх нь ИНБ-ын үр дүнтэй, хараат бус байдлыг бууруулдаг нь үнэн. ИНБ-ын тулгамдсан өөр нэг асуудал бол хүний нөөц хангалтгүй, сайн ажилтнаа авч үлдэж чаддаггүй явдал юм. Санхүүгийн хүндрэл, үйл ажиллагааны таагүй орчны улмаас ялангуяа залуус өөр ажилд шилжих нь элбэг.

Зураг 25. ИНБ-уудад тулгардаг хамгийн том сорилтууд, сүүлийн таван жилийн байдлаар




ИНБ-уудад тулгардаг эрх зүйн орчинтой холбоотой түгээмэл бэрхшээлд нийгмийн даатгалын төлбөр, татварын хувь хэмжээ, татвар төлбөр, тайлагнал болон хууль дагаж мөрдөх байдал, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлууд багтана (Зураг 26). Нийгмийн даатгал төлөлт ИНБ-уудын хувьд нийтлэг бэрхшээл болдог. Богино хугацаатай гэрээт ажилчин байсан ч нийгмийн даатгал заавал төлөх үүрэгтэйгээс гадна уг нийгмийн даатгалын төлбөр хэмжээ өндөр байдаг нь ИНБ-ууд сайн ажилчдаа тогтоон барихад нь хүндрэл учруулдаг ажээ.

Зураг 26. ИНБ-уудад тулгардаг эрх орчинтой холбоотой бэрхшээлүүд




Сүүлийн таван жилийн хугацаанд тулгарсан эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлүүдийг оролцогчид эрэмбэлсэн байдал өмнөх жагсаалтаас бараг өөрчлөгдсөнгүй: нийгмийн даатгал, татвартай холбоотой асуудлууд 1, 2-т эрэмбэлэгджээ (Зураг 27). Асуумж судалгаагаар гараагүй ч, бусдыг гүтгэх, доромжлох гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх хуулийн заалтууд, хувь хүний нууцын тухай хууль нь ИНБ, ялангуяа сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхний ажлыг хүндрүүлдэг. Шүгэл үлээгчийг хамгаалах хуулийн заалтгүйгээс ИНБ, хэвлэл мэдээллийнхний ажил мөн л бэрхшээлтэй тулдаг.

Зураг 27. ИНБ-уудад нийтлэг тулгардаг эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлүүд, сүүлийн таван жилийн байдлаар



Нийгмийн даатгал, татварын хуулиуд, төрийн байгууллагуудын гаргасан шийдвэр, дүрэм журмыг эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлийн гол эх үүсвэр гэж оролцогчид үзжээ (Зураг 28).


Зураг 28. ИНБ-үүдэд тулгардаг эрх зүйн орчинтой холбоотой бэрхшээлүүд, эх үүсвэрээр



Санхүүжилт, түүний эх үүсвэрийн хомс байдал, ИНБ-уудын үр дүн муутай түншлэл, төр засаг, уул уурхайн компаниудын зүгээс ИНБ-д үзүүлэх дэмжлэг, хамтын ажиллагаа сул зэрэг практик бэрхшээлтэй ИНБ-үүд тулгардаг (


Зураг 29). ИНБ, иргэдийн үндсэн зорилго зөрчилдсөн нөхцөлд ИНБ өөрсдийг нь өөрийнхөө зорилгод ашигладаг, эсвэл иргэд өөрсдийнх нь дэмжлэгийг байдаг л зүйл мэтээр хүлээж авдаг гэх иргэд, ИНБ-ын зөрчилдсөн дуу хоолой сонсогддог ч, оролцогчид ИНБ, нөлөөлд өртсөн иргэдтэй итгэлцлийг бэхжүүлэхэд тулгарч болох бэрхшээлд онц ач холбогдол өгсөнгүй.

Зураг 29. ИНБ-уудал тулгардаг практик бэрхшээлүүд




Практик бэрхшээлүүдийг эрэмбэлсэн байдал өмнөх жагсаалтаас онцын зөрүүгүй байв. 1-р байрт санхүүжилт олж авах боломж хязгаарлагдмал байгааг онцолсон бол, ИНБ, төрийн хамтын ажиллагааны сул байдлыг санхүүгийн бэрхшээлээс дээгүүрт тавьсан ИНБ олон байлаа (Зураг 30).

Зураг 30. ИНБ-уудад түгээмэл тулгардаг практик бэрхшээлүүд




Судалгаанд оролцсон дийлэнх ИНБ-ууд өөрсдийн үйл ажиллагаа явуулдаг орчныг “сайн ч биш, муу ч биш” гэж үзсэн бол (Зураг 31), таван оролцогч “муу”, “маш муу” гэж үнэлжээ.

Зураг 31. ИНБ-ууд үйл ажиллагаа явуулдаг орчноо дүгнэсэн байдал



Өнгөрсөн таван жилийн хугацаанд, үйл ажиллагаа явуулдаг орчин онц өөрчлөгдөөгүй гэж олон оролцогч үзсэн бол нийт найман ИНБ орчныг “муудсан”, “эрс муудсан” гэж дүгнэжээ (Зураг 32).


Зураг 32. ИНБ-ын үйл ажиллагааны орчинд гарсан өөрчлөлт, сүүлийн таван жилийн байдлаар



UIH.MN
СУДАЛГААНЫ САН


Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд, үйл ажиллагаа явуулдаг орчинд өөрчлөлт гарсан эсэхийг асуухад олонх оролцогч мөн л “онцын өөрчлөлт гараагүй” гэж үзжээ (Зураг 33).

Зураг 33. ИНБ-ын үйл ажиллагааны орчинд гарсан өөрчлөлт, сүүлийн хоёр жилийн байдлаар




Дээр үзүүлсэнчлэн, ИНБ-ууд төр засагтай олон янзын сувгаар харилцдаг. Тэдгээр сувгуудаас аль нь илүү үр дүнтэй болохыг оролцогчдоос асуухад нүүр тулсан уулзалт, төр засгаас зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн гэж олонх нь хариулжээ. Тэдгээр сувгуудыг үр дүнтэй байдлаар нь эрэмбэлснийг Зураг 34-т үзүүлээ.

Зураг 34. Төр засагтай ИНБ-уудын харилцдаг хамгийн үр дүнтэй сувгууд, сүүлийн таван жилийн байдлаар



Уул уурхайн компаниудтай харилцах үр дүнтэй сувгууд дээрхтэй ижил ба нүүр тулсан уулзалт, уул уурхайн компаниудын зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, ОУИТБС зэрэг олон талт түншлэлийн талбарууд юм (дэлгэрэнгүйг Зураг 35-с үзнэ үү). Уул уурхайн засаглалын асуудал хэлэлцэх өөр нэг сувгийг нээсэн нь КОВИД-19 цар тахлын хязгаарлалтын үеэр, иргэд, уул уурхайн мэргэжилтнүүдтэй засаглалын асуудал хэлэлцэхэд зарим ИНБ-уудын ашигласан Clubhouse зэрэг олон нийтийн сүлжээн дэх цахим тавцангууд юм. Хэлэлцүүлгийн төгсгөлд, талууд бие биеэ илүү сайн ойлгоход энэ мэт цуврал арга хэмжээ чухлыг зарим оролцогчид дурджээ. Шинэчлэлийн хөтөлбөр, зарим асуудлын хүрээнд, ялангуяа төр засгийн оролцоотой бол, уул уурхайн компаниудын хийж чадах зүйл хязгаарлагдмал байдгийг уул уурхайн компаниуд хүлээн зөвшөөрдөг. Энэ мэт нөхцөлд, ИНБ-ууд илүү чөлөөтэй ажиллах боломжтойгоос гадна, өнөөгийн нөхцөл байдлыг өөрчлөх уул уурхайн компаниудын сонирхлыг дэмжигчийн үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

Зураг 35. Уул уурхайн компаниудтай ИНБ-уудын харилцдаг үр дүнтэй сувгууд, сүүлийн таван жилийн байдлаар




Олонх ИНБ-үүд ажил үүргээ хэрэгжүүлэх явцдаа хөндлөнгийн дарамт, айлган сүрдүүлэлтэд өртөөгүй гэж мэдэгджээ. Голдуу төр засаг, улс төрчдийн зүгээс дарамталдаг, айлган сүрдүүлдэг талаар зарим оролцогчид дурдсан байна (

Зураг 36).


UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Зураг 36. ИНБ-уудыг дарамталдаг, айлган сүрдүүлдэг эсэх



Ажил үүргээ хэрэгжүүлэх явцдаа дарамт, айлган сүрдүүлэлттэй тулгарсан гэх цөөн тооны ИНБ-ууд голдуу хэл амаар болон цахим орчинд доромжлуулах, гүтгүүлэх зэргээр дарамтад өртсөн байна (Зураг 37). Бие эрхтэнд заналхийлсэн, шүүхэд өгсөн талаар нэг тохиолдол гарсан нь Их Бага Баяншарга ТББ-ын Борын хэрэг бөгөөд олон байршилд ураны тусгай зөвшөөрлийг цуцлуулсных нь төлөө түүнийг мөрдөн шалгасан, тэргүүлдэг ТББ-ыг нь хаахыг оролдсон тухай тэрээр нийгмийн сүлжээн дэх өөрийн хуудсаараа дамжуулан мэдээлсэн байдаг.³¹

Зураг 37. ИНБ-уудад тулгардаг дарамт шахалт, айлган сүрдүүлэлтийн хэлбэрүүд




UIH.MN
СУДАЛГААНЫ САН

³¹ Л.Бор.

Байнга биш ч гэсэн дарамт, айлган сүрдүүлэлтэд хааяа өртдөг болохоо ИНБ-үүд мэдээлжээ. Дарам, сүрдүүлэлтэд өртөх давтамжийг Зураг 38-д харуулав. Л.Борын хэргийн хувьд, түүний нэхэмжлэлийн дагуу, захиргааны хэргийн шүүхээр төрийн байгууллагаас хууль зөрчин олгосон тусгай зөвшөөрлөө цуцлуулсан компани тэр даруйдаа Борыг нэр төр гутаасан, мөнгө нэхэж дарамталсан хэмээн цагдаад хандаж гомдол гаргасан байна.³²

Зураг 38. ИНБ-үүд дарамт, айлган сүрдүүлэлтэд өртөх давтамж




Нийгмийн амьдрал, үүл уурхайн засаглалын олон асуудалтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомжийг өөрчлөх ажилд ИНБ-үүд идэвхтэй оролцсоор иржээ. Өнгөрсөн таван жилд, Төрийн бус байгууллага, Эрдэс баялаг, Ил тод байдлын тухай хуулиуд, Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд дээр ажилласан гэж ИНБ-үүд тайлагнажээ. Иргэний нийгмийн оролцсон хуулийн төслүүд, оролцсон ИНБ-үүдын тоог Зураг 39-д үзүүлэв.

ОИН.МН
СУДАЛГААНЫ САН


³² Бортой хийсэн ярилцлага

Зураг 39. Өнгөрсөн таван жилийн хугацаанд ИНБ-уудын оролцсон хуулийн төслүүд




Харин, ИНБ-уудын байр суурь, гаргасан саналыг хуулийн төсөлд хэр тусгагдсаныг харвал тун доогуур үзүүлэлт харагдана. Олонх ИНБ-ууд өөрсдийнхөө байр суурь, гаргасан саналаа хуулийн төсөлд тусгуулахад ямар нэг байдлаар нөлөөлөх боломжгүй байдаг (Зураг 40). Харин хуульд биш ч, төрийн байгууллагаас гаргасан цөөхөн шийдвэр, журамд өөрсдийн саналаа тусгажээ. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг зарим чухал хуулийн төсөлд тусгуулахаар иргэний нийгмийн хүчилсэн зарим асуудлыг ОУИТБС-ын тухай бие даасан хуулийн төсөлд тусгана гэсэн шалтгаанаар хүлээж аваагүй байна. ОУИТБС-н тухай хуулийн төсөл олон жил яригдаж байгаа ч, Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж эхлээгүй л байна.

Зураг 40. ИНБ-уудын саналыг төрийн байгууллага хүлээн авч холбогдох хуулийн төслүүдэд тусгасан байдал, сүүлийн таван жилийн байдлаар



Уул уурхайн бодлого, засаглалын олон асуудлаар өөрсдийн байр суурийг хамгаалж, төр засгийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх шаардлага ИНБ-үүдэд байнга тулгардаг. Тэд ихэнхдээ албан тушаалтнуудтай биечлэн уулзах, хэвлэлд ярилцлага өгөх, хэвлэлийн бага хурал хийх, эсвэл олон нийтийн жагсаал зохион байгуулах замаар өөрсдийн эсэргүүцлийг илэрхийлдэг (Зураг 41).


Зураг 41. Төр засгийн шийдвэрийг эсэргүүцэх ИНБ-үүдэд арга замууд, сүүлийн таван жилийн байдлаар



Тэдгээр арга замуудаас хэвлэлд нийтлэл гаргах, ярилцлага өгөх, шүүхэд нэхэмжлэл гаргах, хэвлэлийн бага хурал зохион байгуулах аргуудыг хамгийн үр дүнтэй гэж үздэг. Тэр дундаа, шүүхэд нэхэмжлэл гаргах замаар төр засгийн шийдвэрийг эсэргүүцэх арга маш амжилттайд тооцогддог. Тодорхой үр чадвар, эх үүсвэр шаарддаг ч, нийтийн эрх ашгийн өмгөөллийн асуудлаар шүүхэд хандах нь захиргааны шийдвэрийг өөрчлөх үр дүнтэй арга байдгийг Нээлттэй Нийгэм Хүрээлэн зэрэг түршлагатай байгууллагуудын жишээн дээр харж болно.




Зураг 42. Төр засгийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх ИНБ-ын үр дүнтэй арга хэлбэрүүд



Компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэхэд хэвлэлийн бага хурал хийх, хэвлэлд нийтлэл гаргах, ярилцлага өгөх аргуудыг ИНБ-ууд өргөн ашигладаг. Салбарт хяналт тавьдаг төрийн байгууллага, салбарын холбоодод гомдол гаргах аргыг төдийлөн ашигладаггүй ажээ (Зураг 43).


Зураг 43. Компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэх ИНБ-ын арга хэлбэрүүд, сүүлийн таван жилийн байдлаар



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Хэвлэл мэдээллийн салбартай хамтарч ажиллах нь компанийн шийдвэр, үйл ажиллагаанд нөлөөлөх бас нэг арга юм (Зураг 44). Сэтгүүлчдийг хэвлэлийн бага хуралд урих, зарим төрлийн мэдээллийг хэвлэл мэдээллийн гол хэрэгслээр цацахад төлбөртэй байдаг нь ИНБ-уудад зарим нэг хүндрэлийг үүсгэдэг. Мөн, шүүхэд нэхэмжлэл гаргах аргыг компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэхэд ашиглахад тохиромжтой гэж үздэг. Энэ тохиолдолд, төр засгийн шийдвэртэй холбоотой хэргийг хянан хэлэлцдэг захиргааны хэргийн шүүхэд хандах боломжгүй юм.

Зураг 44. Компанийн шийдвэр, үйл ажиллагааг эсэргүүцэхэд ИНБ-уудын ашигладаг үр дүнтэй аргууд



2.7. Төр засаг, бусад оролцогч талуудын дэмжлэг амин чухал хэвээр байна


Энэ бүлэгт, өөрсдийн зорилгыг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ гэж ИНБ-уудын үздэг янз бүрийн боломжуудыг авч үзсэний дотор төр засаг, компани, бусад ИНБ-ууд зэрэг хамтрагч талуудаас ИНБ-уудын хүсэн хүлээдэг гол асуудлуудыг анхаарч үзсэн болно.

Төрөөс хүлээх хүлээлтийн тухайд, уул уурхайн бодлого, засаглал дахь ИНБ-ын оролцоог бэхжүүлэх, мэдээ, мэдээллийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, ИНБ-уудыг чадавхжуулах, оролцооны талбараар хангах чиглэлийн дэмжлэг хамгийн чухалд тооцогдоно. Төр засгаас хүлээх ИНБ-уудын хүлээлтийг Зураг 45-д үзүүлэв. ИНБ-ууд олон агентлагууд, ялангуяа цагдаа, мэргэжлийн хяналт зэрэг хууль хяналтын байгууллагуудын дунд нааш цааш шидэгдсээр учраа олохоо больдог. Түүнчлэн, мэдээлэл авах хүсэлт тавихад нь ИНБ-уудын тэртэй тэргүй мэддэг, мэдээллийн хувьд бүрэн бус, эсвэл хангалтгүй Шилэн данс эсвэл бусад холбогдох мэдээллийн санд ханд бий гэх нь олонтоо. Энэ нөхцөлд төрийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг хууль, дүрэм журамд илүү тодорхой болгох нь чухал байна. Заримдаа өргөдөл, хүсэлтэд хуульд заасны дагуу хариу өгдөггүй бөгөөд ИНБ-ын гаргасан хүсэлтийг хянах олон нийтийн бүртгэлийн тогтолцоо байдаггүй.

ИНБ, олон нийттэй зөвлөлдөх хуулийн шаардлагууд ихэвчлэн цаасан дээр л үлддэг. Албан ёсны ажлын хэсэг, зөвлөлд ИНБ-уудыг оролцуулдаг явдал түгээмэл болсон ч, тэднийг төрийн байгууллагууд өөрөө сонгодог, түүнчлэн, асуудлыг төрийн албан тушаалтнууд давамгайлсан орчинд олонхын саналаар шийдвэрлэдэг, эсвэл ИНБ-д зөвхөн зөвлөх эрх мэдэл олгодгоос ИНБ-ын гишүүдийн гаргасан санал, байр суурь эцсийн шийдвэрт тусгагддаггүй явдал нийтлэг тохиолдоно.


ИНБ-ын үйл ажиллагааг зохицуулах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах төрийн төлөвлөгөө ИНБ-уудын үйл ажиллагаа, санхүүг ил тод болгох, ИНБ-уудыг бизнес, улс төрийн зорилгоор ашиглах боломжуудыг хязгаарлахын сацуу, иргэний нийгмийг гадаадаас санхүүжүүлэх боломжийг хүмих, хязгаарлахад чиглэгдсэн бололтой. Эдгээр алхмыг өнөөгийн хуулийн цоорхойг урвуулан ашиглахтай тэмцэх хууль ёсны арга хэмжээ гэж үзэж болох ч, энэ мэт түрэмгий арга хэмжээ нь иргэний нийгмийн эрх зүйн орчныг хэт чангатгаж иргэний нийгмийн орчныг хүмих сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм. Төр засаг эдгээр өөрчлөлтийг хийхийн хажуугаар, нийгмийн даатгал, татварын хууль тогтоомжуудыг эргэж харах; шүгэл үлээгч, мэдээллийн нээлттэй байдлын тухай хууль тогтоомжийг батлах, ИНБ-уудыг чадавхжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх замаар ИНБ-уудыг хамгаалах арга хэмжээ авах зэргээр ИНБ-уудад үзүүлж буй дэмжлэгээ өргөжүүлэх хэрэгтэй.

Зураг 45. ИНБ-ын оролцоог бэхжүүлэх талаар төс засгаас хүлээж буй дэмжлэг



ИНБ-тай хамтран ажиллах бодлогоо эргэн харах, байгаль орчин, нийгэм, засаглалын талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа тогтмол тайлагнах, уул уурхайн компани, нутгийн иргэдийн хоорондох зөрчлийг шийдвэрлэх механизмыг бий болгохыг ИНБ-ууд уул уурхайн компаниудаас чухалчлан хүсдэг (Зураг 46). Уул уурхайн том компаниуд, салбарын холбоод, ИНБ-ууд мэдээлэл солилцох, чадавхжуулах зорилгоор тогтмол уулзалтуудыг зохион байгуулдаг. Уул уурхайн компани, ИНБ-ууд хамтын ашиг сонирхлын хүрээнд, Хариуцлагатай уул уурхайн санаачилга, ОУИТБС зэрэг хоёр болон олон талт түншлэлийн талбараар дамжуулан хамтын ажиллагаагаа сайжруулах шаардлагатай байна.


Зураг 46. ИНБ-ын оролцоог бэхжүүлэх талаар компаниудаас хүлээж буй дэмжлэг



Уул уурхайн бодлого, засаглал дах өөрсдийн үүрэг, оролцоог сайжруулах хүчин чармайлтынхаа хүрээнд, ИНБ хоорондын хамтын ажиллагаа, чадавхаа бэхжүүлэх, олон улсын сүлжээнд нэгдэх асуудалд ИНБ-ууд гол ач холбогдол өгч байна (

Зураг 47). ИНБ-уудад тулгардаг гол сорилтуудад ИНБ-ууд хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, иргэний нийгмийн хөдөлгөөнийг шинэ чадварлаг боловсон хүчнээр сэлбэх, хамтарсан төсөл боловсруулж, хэрэгжүүлэх, тэдгээрийн санхүүжилтийг босгох үйл ажлууд багтана. ИНБ-ууд өөрсдийн үйл ажлыг сурталчилж, бүх оролцогч тал, олон нийттэй харилцах оновчтой стратегийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Иргэний нийгмийн орон зайд нөлөөлөх амин чухал асуудлаар ИНБ-ууд нэгдсэн байр суурьтай байх нь тэдэнд хамааралтай аливаа хууль тогтоомжийн төслийг хэлэлцэх явцад тэдний анхаарах чухал асуудал мөн. ИНБ-ууд өөрсдийн ололт амжилт, ялангуяа өнгөрсөн хугацаанд олж авсан сургамжуудаа баримтжуулах нь цаашдын үйл хэрэгт нь тустай. Энэ бүх ажлуудыг хэрэгжүүлэхэд, чадавхаа дээшлүүлэх, үйл хэрэг нэгтгүүдээсээ суралцах ажлыг тасралтгүй зохион байгуулах, олон нийтийн индрүүдийг ашиглан, оролцогч талуудын танилцуулсан технологи, шинэ боломжуудыг ашиглах, сурч мэдэх нь юунаас илүү чухал байна. Түүнчлэн өөрсдийн сурталчилдаг ил тод, хариуцлагатай байдлыг өөрсдөөсөө эхлэх нь зүйтэй бөгөөд энэ нь хандивлагч зэрэг бусад оролцогч талуудтай харилцаагаа бэхжүүлэхэд том хөшүүрэг болох нь дамжиггүй. Хэт их мэдээллийн энэ эринтэй хөл нийлүүлэн, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтарч ажиллах нь ИНБ-уудын хувьд онцгой ач холбогдолтой юм.

Зураг 47. Хамтын ажиллагаагаа бэхжүүлэх талаар бусад ИНБ-уудаас хүлээж буй дэмжлэг



3. Дүгнэлт, зөвлөмжүүд

3.1. Онцлох үр дүнгийн товчоон, дүгнэлтүүд

Монгол Улсын эдийн засгийн гол салбар-уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах, ардчиллыг бэхжүүлэхэд иргэний нийгэм өнгөрсөн 20-иод жилийн хугацаанд нэн чухал үүрэг гүйцэтгэж ирлээ. ИНБ-уудын оролцоо, дэмжлэгийн үрээр олборлох салбарын ил тод байдал сайжирч, нутгийн иргэд эрх ашгаа хамгаалдаг, иргэний нийгэм нь төр засгийн зарим буруу шийдвэртэй шүүх, бусад арга хэрэгслээр дамжуулан тэмцэж чаддаг болов. Түүнчлэн, ИНБ-ууд олон талт түншлэлийн тавцан, бодлогын хэлэлцүүлгийн байнгын оролцогч, нөлөө бүхий хамтрагч болжээ.

Сүүлийн жилүүдэд, уул уурхайн засаглал дах иргэний нийгмийн орон зайд томоохон сорилтууд тулгарах болов. КОВИД-19 цар тахалтай холбогдуулан төр засгийн авсан хязгаарлалтын арга хэмжээний улмаас, өмнө нь гол төлөв олон нийтийн санаа бодлыг харгалзан шийддэг байсан олон асуудлыг төр засаг дангаар шийддэг болов. Эдийн засгийн өсөлт удааширсантай холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалтыг татах яаралтай арга хэмжээ авах шаардлагатай болсон төр засаг том төслүүдэд эргэлзсэн аливаа дуу хоолойг үл тэвчих байр суурь баримтлах болсноор ИНБ-н зарим идэвхтнүүдийг мөрдөн шалгаж, иргэний нийгмийг харлуулах үг яриа гарах болов. Эдийн засгийн гол салбар уул уурхайг эсэргүүцэгсдийг нүд үзүүлэж, буланд шахав. ИНБ-н үүрэг роль, цаашлаад ардчиллыг улс орон бүрд тохирох төрийн хэлбэр мөн эсэхэд эргэлзсэн дуу хоолой ихэссэн энэ цагт, иргэний нийгмийн орон зай хүмигдаж буй дэлхий нийтийн чиг хандлага, геополитикийн чиг баримжааны нөлөөлөл нөхцөл байдлыг өөрчилж чадсангүй. Энэ үед, зарим бүлэг хүмүүс ТББ-ын нэрээр уул уурхайн компаниудтай хүчирхийллийн аргаар тэмцэж, мөнгө дарамтлагч нэр зүүсэн нь иргэний нийгмийн нэр хүндийг сэвтүүлээд зогсохгүй, үр дүнтэй яриа хэлцлийн замаар хуулийн хүрээнд зорилгоо хэрэгжүүлэх арга замыг сонгосон бусад ИНБ-уудад сөргөөр нөлөөлсөн нь дамжиггүй.

Энэ мэт бэрхшээлүүд байгаа ч, уул уурхайн засаглалыг сайжруулахад иргэний нийгмийн оролцоо чухал гэдэгтэй маргашгүй. Иргэний нийгмийн хөдөлгөөн үүссэн анхдагч шалтгаан нь Монгол Улсад хаа сайгүй явагдсан хариуцлагагүй уул уурхайн эсрэг иргэдийн дургүйцэл байсан юм. Байгаль орчин, иргэдийн амьдрал, эдийн засагт үзүүлдэг нөлөөллийг нь бусад салбаруудтай харьцуулшгүй эл салбарт тулгардаг олон сорилт, бэрхшээлийг шийдвэрлэхэд иргэний нийгэм орлуулшгүй үүрэг гүйцэтгэнэ. Тодорхой чиглэлээр тогтвортой ажилладаг ИНБ-ууд нийтийн эрх ашгийг хамгаалах талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэргэшүүлэх сургалт явуулах чадвартай байдаг. Дэлхий дахинд өрнөсөн эрчим хүчний шилжилттэй хөл нийлүүлэх тулгамдсан шаардлагаас үүдсэн, ашигт малтмал олборлолтоо дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнд нийцүүлэх, эсвэл зөвхөн дотоодын шударга эрчим хүчний шилжилтийг хангахад чиглүүлэхтэй холбоотой шинэ сорилтууд бий болов. Худал мэдээллээр дүүрсэн мэдээллийн халилтын энэ эринд, бодлогын асуудлаар санал солилцох орон зайг ашиглах, талуудын хариуцлагыг сайжруулахад ИНБ-н өвөрмөц үр чадвар, мэдлэг тус болно.

Иргэний нийгэмд тулгардаг өнөөгийн олон бэрхшээлийн нэлээдгүйг дан ганц иргэний нийгмийн өөрийнх нь хүчин чармайлтаар шийдвэрлэх боломжтой. ИНБ-ууд үр чадвартай ажилтнуудаа тогтоон барих, тогтвортой үйл ажиллагаа явуулах санхүүжилт олж авах, янз бүрийн оролцогч талуудтай үр дүнтэй хамтран ажиллах зэрэг сорилттой тулсаар ирлээ. Засаглалын асуудлаар ажилладаг ИНБ-уудыг дэмждэг цөөн тооны хандивлагч болон олон улсын байгууллагууд бий. Төр засаг, уул уурхайн компаниудын ИНБ-уудтай байгуулсан түншлэл ихэвчлэн нэр төдий, үр дүнгүй

байдаг. Иргэний нийгмийн чадавх, хоорондын уялдаа холбоо, түншлэл асуудалтай хэвээр байна. Эдгээр бэрхшээлийг үр ашигтай шийдвэрлэхгүй бол төр засаг, уул уурхайн компаниудтай үр дүнтэй яриа хэлцэл хийх боломж ИНБ-үүдэд үлдэхгүй болох эрсдэлтэй. ИНБ-үүд өөрсдийн үйл хэргийг олон нийтэд зөвөөр тайлбарлаж, төр засаг, уул уурхайн салбарыг эсэргүүцэгч, шүүмжлэгч бус, харин салбарын засаглалыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулдаг тоглогч гэдгээ батлан харуулах хэрэгтэй. Үүний тулд, өнгөрсөн 20 жилийн турш төр засаг, уул уурхайн компаниудтай түншлэл, дэвшилтэт харилцааг хөгжүүлэн, яриа хэлцэл явуулсан арвин их туршлагатай бусад ИНБ-үүдтай үр дүнтэй хамтарч ажиллах шаардлагатай байна. Үүний зэрэгцээ, төр засаг, уурхайн компаниудтай үр дүнтэй яриа хэлцэл хийх орон зай олгох, ИНБ-үүдын түншлэл, санхүүжилтийн шинэлэг арга хэрэгслүүдийг бий болгох зэргээр иргэний нийгмийн хөдөлгөөнийг дэмжих төр засгийн дэмжлэгийг үе шаттайгаар нэмэгдүүлэх нь чухал байна.

3.2. Зөвлөмж

Дээрх үр дүнд тулгуурлан дараах зөвлөмжүүдийг хүргэв.


